



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 07 дугаар сарын 01  
№ 25 (1223)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

455.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай	1785
456.	Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1788
457.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1791
458.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай	1792
459.	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1793
460.	Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1794
461.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1795
462.	Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1797
463.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1809
464.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1814
465.	Үндэсний их баяр наадмын тухай /Шинэчилсэн найруулга/	1816
466.	Үндэсний их баяр наадмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1857
467.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1858

468.	Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1859
469.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		1860
470.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай		1862
471.	Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		1863
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>			
472.	Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг батлах тухай	Дугаар 26	1864
473.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 32	1885
474.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 33	1889
475.	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах тухай	Дугаар 34	1890
476.	Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг шинэчлэн тогтоож, зарим орчныг олон нийтэд нээлттэй болгох тухай	Дугаар 37	1898
477.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилох тухай	Дугаар 38	1901
478.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 39	1902

## ТЭГХЭМЭР

### Хувилгал Зөвшөөрөл

᠒᠐7᠘᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒02᠒	Хувилгал Зөвшөөрөл
77᠘᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
6᠙᠘᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠐᠗᠘᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠒᠐᠗᠘᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠙᠗᠘᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠒᠐᠗᠘᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠙᠗᠘᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠗᠐7᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠙67᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠑67᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠑᠗7᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
7᠒7᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠗᠒7᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл
᠐᠑7᠖	Хувилгал Зөвшөөрөл	᠒᠒᠒᠒	Хувилгал Зөвшөөрөл





**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны 05 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН  
2023 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,  
2024-2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2023 он	2024 он	2025 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.0	5.1	6.1
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	17,312.2	18,511.9	20,496.7
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.7	33.1	32.8
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	19,219.1	20,077.8	21,744.8
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	36.3	35.9	34.8
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,305.6	858.8	1,666.9
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.5	1.5	2.7
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,906.8	-1,565.9	-1,248.1
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-3.6	-2.8	-2.0



7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	4,484.4	5,019.5	5,436.2
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.5	9.0	8.7
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	34,428.4	33,556.0	37,443.0
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	65.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд <sup>1</sup> заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	604.8	569.6	590.0
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.1	1.0	0.9

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

<sup>1</sup>Нийгмийн халамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 08 дугаарт нийтлэгдсэн.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.1.22 дахь заалт нэмсүгэй:

“3.1.22. “Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис” гэж Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протоколын хавсралтад тусгагдсан гидрофторт нүүрстөрөгчийн төрлийн бодисыг.”

**2 дугаар зүйл.** Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтын “озон задалдаг” гэсний дараа “, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Агаарын тухай хуулийн 25 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### “25 дугаар зүйл. Озоны үе давхаргыг хамгаалах

25.1. Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт, тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.

25.2. Тухайн жилд импортлох озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн тоо хэмжээг төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтоож, импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоно.

25.3. Тухайн жилд импортлох озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисын тоо хэмжээг импортлогч этгээдэд хуваарилах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25.4. Энэ хуулийн 25.1-д заасан жагсаалтад орсон бодис, тоног төхөөрөмжийн тухайн жилд импортолсон, худалдсан, ашигласан, үйлдвэрлэсэн тухай тайлан, мэдээллийг гаалийн байгууллага болон энэ хуулийн 25.2-т заасан импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл авсан аж



ахуйн нэгж, байгууллага, иргэн жил бүрийн 12 дугаар сард багтаан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

25.5.Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин боловсруулах, дахин цэнэглэх, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг суурилуулах, ашиглах, засвар үйлчилгээ хийх, устгах үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

25.6.Энэ хуулийн 25.5-д заасан мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, эрх олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25.7.Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, хураагдсан бодисыг устгах, зайлуулах, нөөцөлж хадгалах асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.”

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ**

᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠑ өдөр /᠒᠐᠒᠒ - ᠑᠒ сарын ᠒᠑/ өдөр  
Төрийн мэдээлэл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР

᠒᠐᠒᠒ оны ᠑᠒ сарын ᠒᠑ өдөр /᠒᠐᠒᠒ - ᠑᠒ сарын ᠒᠑/ өдөр  
Төрийн мэдээлэл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР

մտնաբերութեամբ արժանանալու իր ցիտաքիմիայի, ներհանրաբանական և սոցիալական գիտությունների ոլորտներում, կատարելու իր անձնական ներդրումը գիտության, բնական հանրության, մշակութային և հասարակական կյանքի համար: Դրա համար կարևոր է պահպանել համագործակցության բարձր մակարդակը, բարձրացնել համագործակցության մակարդակը, խթանել համագործակցության զարգացումը: «

10. Կարևոր է կատարել իր անձնական ներդրումը գիտության, բնական հանրության, մշակութային և հասարակական կյանքի համար: Դրա համար կարևոր է պահպանել համագործակցության բարձր մակարդակը, բարձրացնել համագործակցության մակարդակը, խթանել համագործակցության զարգացումը: «

11. Կարևոր է կատարել իր անձնական ներդրումը գիտության, բնական հանրության, մշակութային և հասարակական կյանքի համար: Դրա համար կարևոր է պահպանել համագործակցության բարձր մակարդակը, բարձրացնել համագործակցության մակարդակը, խթանել համագործակցության զարգացումը: «

12. Կարևոր է կատարել իր անձնական ներդրումը գիտության, բնական հանրության, մշակութային և հասարակական կյանքի համար: Դրա համար կարևոր է պահպանել համագործակցության բարձր մակարդակը, բարձրացնել համագործակցության մակարդակը, խթանել համագործակցության զարգացումը: «

13. Կարևոր է կատարել իր անձնական ներդրումը գիտության, բնական հանրության, մշակութային և հասարակական կյանքի համար: Դրա համար կարևոր է պահպանել համագործակցության բարձր մակարդակը, բարձրացնել համագործակցության մակարդակը, խթանել համագործակցության զարգացումը: «

14. Կարևոր է կատարել իր անձնական ներդրումը գիտության, բնական հանրության, մշակութային և հասարակական կյանքի համար: Դրա համար կարևոր է պահպանել համագործակցության բարձր մակարդակը, բարձրացնել համագործակցության մակարդակը, խթանել համագործակցության զարգացումը: «

15. Կարևոր է կատարել իր անձնական ներդրումը գիտության, բնական հանրության, մշակութային և հասարակական կյանքի համար: Դրա համար կարևոր է պահպանել համագործակցության բարձր մակարդակը, բարձրացնել համագործակցության մակարդակը, խթանել համագործակցության զարգացումը: «

16. Կարևոր է կատարել իր անձնական ներդրումը գիտության, բնական հանրության, մշակութային և հասարակական կյանքի համար: Դրա համար կարևոր է պահպանել համագործակցության բարձր մակարդակը, բարձրացնել համագործակցության մակարդակը, խթանել համագործակցության զարգացումը: «



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.6.1.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах:

15.6.1.а.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин боловсруулах, дахин цэнэглэх, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, засвар үйлчилгээ хийх, устгах.”

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ





# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтын “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилал”-ын “Төслийн ангилал” хэсгийн 7 буюу “Бусад төсөл”-ийн “хот байгуулалт” гэсний дараа “хөргөлт, агааржуулалтын систем” гэж, “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэсэн хэсгийн 7 буюу “... орон нутгийн чанартай барилга байгууламж” гэсний дараа “-озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис агуулсан хөргөлт, агааржуулалтын системтэй барилга байгууламж” гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Улаанбаатар хотын төв

Улаанбаатар хотын төв, 100 - 0000, 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хотын төв, 100 - 0000, 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

6 хэсэг, 1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтын “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилал”-ын “Төслийн ангилал” хэсгийн 7 буюу “Бусад төсөл”-ийн “хот байгуулалт” гэсний дараа “хөргөлт, агааржуулалтын систем” гэж, “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэсэн хэсгийн 7 буюу “... орон нутгийн чанартай барилга байгууламж” гэсний дараа “-озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис агуулсан хөргөлт, агааржуулалтын системтэй барилга байгууламж” гэж тус тус нэмсүгэй.

Улаанбаатар хотын төв, 100 - 0000, 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 16 дахь заалт нэмсүгэй:

“16/озоны давхаргыг хамгаалах талаар бодлого, хөтөлбөр боловсруулах, холбогдох дүрэм, журмыг баталж, хэрэгжилтийг хангах;”

**2 дугаар зүйл.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтын дугаарыг “17” гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Борлуулсан хувиар

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ - 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Хуулийн төслийн үндсэн дээр  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ

16-дугаар заалт нэмж оруулах:  
“16/озоны давхаргыг хамгаалах талаар бодлого, хөтөлбөр боловсруулах, холбогдох дүрэм, журмыг баталж, хэрэгжилтийг хангах;”

17-дугаар заалтыг өөрчлөх:  
“17/...”

17-дугаар заалтыг нэмж оруулах:  
“17/...”

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ  
Г.ЗАНДАНШАТАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАРИЛГЫН ТУХАЙ ХУУльд НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “хязгаарлахгүй байх” гэсний дараа “ хөргөлт, агааржуулалтын систем нь озон задалдаг бодисыг орлуулах бодис ашигласан байх” гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**Урьтгал ᠑᠓**

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “хязгаарлахгүй байх” гэсний дараа “ хөргөлт, агааржуулалтын систем нь озон задалдаг бодисыг орлуулах бодис ашигласан байх” гэж нэмсүгэй.

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “хязгаарлахгүй байх” гэсний дараа “ хөргөлт, агааржуулалтын систем нь озон задалдаг бодисыг орлуулах бодис ашигласан байх” гэж нэмсүгэй.

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “хязгаарлахгүй байх” гэсний дараа “ хөргөлт, агааржуулалтын систем нь озон задалдаг бодисыг орлуулах бодис ашигласан байх” гэж нэмсүгэй.

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “хязгаарлахгүй байх” гэсний дараа “ хөргөлт, агааржуулалтын систем нь озон задалдаг бодисыг орлуулах бодис ашигласан байх” гэж нэмсүгэй.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх заалтын “устгах” гэсний дараа “, дахин боловсруулах, тоног төхөөрөмжийг суурилуулах” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн дараах заалт, дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/21 дүгээр зүйлийн 21.1.10 дахь заалт:**

“21.1.10.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоход:

21.1.10.а.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар нь 675-аас их нүүрсхүчлийн хийн эквиваленттай тэнцэх орлуулах бодис бол 40 000-100 000;

21.1.10.б.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар нь 675-аас ихгүй нүүрсхүчлийн хийн эквиваленттай тэнцэх орлуулах бодис бол 11 000-27 000.”

#### **2/21 дүгээр зүйлийн 21.1.11 дэх заалт:**

“21.1.11.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис агуулсан дараах бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоход:”

#### **3/21 дүгээр зүйлийн 21.1.11.в дэх дэд заалт:**

“21.1.11.в.үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний агааржуулалт, хөргөх, халаах систем, тоног төхөөрөмж болон бусад бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж 40 000-100 000.”

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ойн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/3 дугаар зүйлийн 3.1.25-3.1.29 дэх заалт:**

“3.1.25. “ойн үр” гэж мод, бут, сөөг үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээхэд ашиглаж байгаа үржлийн зориулалттай үр хөврөл бүхий эрхтнийг;

3.1.26. “үржлийн материал” гэж мод, бут, сөөг үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх зориулалт бүхий үр, ургал эрхтэн, үндэс, мөчрийн тайрдас, тарьц, суулгацыг;

3.1.27. “ойн үрийн мужлал” гэж экологийн болон өндөршлийн хувьд төстэй бүс нутагт орших удамшил, гадаад илрэлийн хувьд адил шинж тэмдэг бүхий байгалийн ойн газар нутгийг;

3.1.28. “ойн аж ахуйн арга хэмжээ” гэж ойг үржүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах, зохистой ашиглах, ойн тооллого, зохион байгуулалт, арчилгаа, цэвэрлэгээ хийхэд чиглэсэн цогц арга хэмжээг;

3.1.29. “агро-ойн аж ахуй” гэж тухайн нутаг дэвсгэрийн хөрс, уур амьсгал, ус зүйн нөхцөлийг сайжруулах, таримал болон байгалийн ургамлын ургах орчныг дэмжсэн аж ахуйн арга хэмжээг.”

#### **2/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:**

“14.3. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.3.1. ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах, агро-ойн аж ахуйн талаарх хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, ойн аж ахуйн арга хэмжээг удирдан зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

14.3.2. улсын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

14.3.3.улсын ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх;

14.3.4.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ашиглах зориулалтаар батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулах, энэ хуулийн 30.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;

14.3.5.ойн аж ахуйн арга хэмжээний заавар, аргачлалыг батлах, холбогдох стандарт, журмыг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх;

14.3.6.ойн мэргэжлийн боловсон хүчний давтан болон ойн мэргэшлийн зэрэг олгох сургалтыг энэ хуулийн 41.2.2-т заасныг үндэслэн холбогдох их, дээд сургуультай хамтран зохион байгуулах;

14.3.7.ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх шинэ техник, технологийг судлах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүн, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

14.3.8.таримал ой ургуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах, талуудын уялдаа холбоог зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

14.3.9.агро-ойн аж ахуйн арга хэмжээг удирдан зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

14.3.10.ойн аж ахуйн арга хэмжээний зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал хийх ажлыг зохион байгуулах, баталгаажуулах;

14.3.11.ойн үрийн улсын нөөцийн сан байгуулах, баяжуулах, үйл ажиллагааг эрхлэх, үржлийн материал бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэх;

14.3.12.үржлийн материалын гарал үүслийн болон чанарын гэрчилгээний загвар боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах;

14.3.13.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, эргүүл, харуул ажиллуулах, бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тодорхой үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж, шийдвэрлүүлэх;



14.3.14.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

14.3.15.хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах талаар бусад улстай гэрээ, хэлэлцээр байгуулж, хамтран ажиллах;

14.3.16.ашиглалтын болон хамгаалалтын бүсийн ойн менежментийг сайжруулах, ойн нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой ойн техник, технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх;

14.3.17.ойн экологи, эдийн засгийн үнэлгээг боловсруулах;

14.3.18.энэ хуулийн 7.2-т заасны дагуу ойн тооллого, ой зохион байгуулалт хийх, ойн мониторингийн системийг хөгжүүлэх, ойн сангийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх;

14.3.19.ойн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах;

14.3.20.таримал ойг улсын ойн санд хүлээн авах;

14.3.21.ойн ангийн үлгэрчилсэн дүрмийг батлах;

14.3.22.ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт гаргах;

14.3.23.ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох;

14.3.24.мод үржүүлэг, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагад газар эзэмшүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мөнгөн урамшуулал олгох, тэдгээрт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж шийдвэрлэх;

14.3.25.ойн нөөцийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх ажилд дотоод хяналтыг зохион байгуулах.”

### **3/30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг:**

“30.6.Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”



#### **4/30<sup>1</sup> дүгээр зүйл:**

##### **“30<sup>1</sup> дүгээр зүйл. Үржлийн материал бэлтгэх**

30<sup>1</sup>.1. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд тухайн ойн үрийн мужлалаас гарал үүсэлтэй, стандартын шаардлага хангасан үрийг ашиглана.

30<sup>1</sup>.2. Ойн үрийн мужлалын хилийн заагийг ойн шинжлэх ухааны байгууллагын саналыг үндэслэн ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.

30<sup>1</sup>.3. Байгалийн гамшгийн улмаас үр нөөцөлж чадаагүй, эсхүл үрийн бага ургацын жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үр нийлүүлэх, үр шинэчлэх зорилгоор удамшлын болон тарилтын сайн чанарын үрээр ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр ойн үрийн улсын нөөцийн санг бүрдүүлнэ.

30<sup>1</sup>.4. Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

30<sup>1</sup>.5. Итгэмжлэгдсэн лаборатори ойн үрийн улсын нөөцийн санд нийлүүлэх болон худалдан борлуулах ойн үрийн шинжилгээ хийж, чанарын гэрчилгээг олгоно.

30<sup>1</sup>.6. Гарал үүслийн болон чанарын гэрчилгээтэй үржлийн материалыг худалдан борлуулна.

30<sup>1</sup>.7. Гарал үүсэл нь тодорхойгүй, эсхүл итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр стандартын шаардлага хангаагүй болох нь тогтоогдсон үрийг худалдах, импортлохыг хориглоно.

30<sup>1</sup>.8. Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэх, худалдах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

**2 дугаар зүйл.** Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын “жил бүр” гэсний өмнө “таримал ой, мод үржүүлгийн газар, модлог ургамлын үрийн бодлого боловсруулж баталж, биелэлтийг хангуулах,” гэж, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “химийн бодис” гэсний дараа “, биологийн бэлдмэл” гэж, 28 дугаар зүйлийн гарчгийн “цэвэрлэгээ хийх” гэсний дараа “, хилийн зурвас гаргах, сэргээх” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Ойн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



### **1/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:**

“4.3.Энэ хуулийн 4.2-т заасны дагуу таримал ой, түүний дагалт байлгийг өмчлүүлэх асуудлыг орон нутгийн ойн ангийн тодорхойлолтыг үндэслэн энэ хуулийн 30.5-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.”

### **2/17 дугаар зүйлийн 17.2.8 дахь заалт:**

“17.2.8.аймгийн байгаль орчны газрын харьяанд сум дундын ойн анги, нийслэлийн байгаль орчны газарт ойн асуудал эрхэлсэн нэгж байгуулж, бүтэц, орон тоог батлан, тэдгээрийн даргыг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх;”

### **3/30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг:**

“30.5.Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх болон таримал ойг үнэлэх, хүлээн авах, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

**4 дүгээр зүйл.**Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “Төрийн” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн” гэж, 14 дүгээр зүйлийн гарчгийн “Ойн асуудал эрхэлсэн нэгж” гэснийг “Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүрэн эрх” гэж, мөн зүйлийн 14.1 дэх хэсгийн “Аймаг,” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/, аймаг,” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Ойн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “төв” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.1.11 дэх заалтын “, биелэлтийг дүгнэн, ажил гүйцэтгэгчийг санхүүжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 13.1.13 дахь заалтын “боловсруулах,” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.3.8 дахь заалтын “, ойн ангийн даргыг томилох, чөлөөлөх” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10, 13.1.12, 13.1.15-13.1.34 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## СОНЪҶ СИМУЛАСОН

Ҷаҳиштиношумон Ҳафтар

2020 Ҳисаб ва Ҷабҳуи Ҷаҳиштиношумон 100 - 9 Ҷаҳиштиношумон

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

10\6 Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон 100\6 Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон Ҷаҳиштиношумон :

















## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

#### **1/8 дугаар зүйлийн 8.14 дэх хэсэг:**

“8.14. Захиалагч ерөнхий гэрээний дагуу худалдан авахаас бусад жил бүр давтагддаг ажил, зөвлөхийн бус үйлчилгээний нэгж үнэ болон бусад нөхцөлийг гурав хүртэл жилийн хугацаанд тогтоосон тендер шалгаруулалт зохион байгуулан гэрээ байгуулж болно.”

#### **2/40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсэг:**

“40.6. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ажил гүйцэтгэх төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төсөвт өртгийг хуулиар нэмэгдүүлэн баталсан бол захиалагч магадлалын дүгнэлтэд үндэслэн тухайн ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнэ, ажлын тоо хэмжээг нэмэгдүүлэн баталсан төсөвт өртөгт багтаан нэг удаа өөрчилж болно.”

#### **3/43 дугаар зүйлийн 43.8, 43.9 дэх хэсэг:**

“43.8. Төсвийн жил дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааны хугацаа дуусахаас өмнө захиалагчид гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлнэ.

43.9. Гүйцэтгэгч энэ хуулийн 43.8-д заасан гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол түүнийг гэрээний үүргээ зөрчсөнд тооцож, гүйцэтгэлийн баталгааг орлого болгоно.”

#### **4/55 дугаар зүйлийн 55.10 дахь хэсэг:**

“55.10. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол хянан шийдвэрлэх хугацаанд энэ хуулийн 29.1-д заасан хугацаа түр зогсоно.”

**2 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “Захиалагч” гэсний дараа “тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор” гэж, 52<sup>1</sup> дүгээр зүйлийн 52<sup>1</sup>.1 дэх хэсгийн “эрх бүхий” гэсний дараа “улсын ерөнхий байцаагч,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг:**

“20.4.Захиалагч тендерийн баталгааны хэмжээг төсөвт өртгийн 0.5 хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.”

**2/24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг:**

“24.5.Тендерт оролцогч өөрийн тендерийн хүчинтэй байх хугацаар 30-аас доошгүй хоног байхаар тендерт заана.”

**4 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “бэлтгэнэ” гэснийг “бэлтгэж болно” гэж, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтын “хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас” гэснийг “хувиас” гэж, 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь заалтын “40.4-т” гэснийг “40.4, 40.6-д” гэж, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “гэрээний үнийн дүнгийн 5” гэснийг “тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсгийн “ажил,” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн, 52<sup>1</sup> дүгээр зүйлийн 52<sup>1</sup>.2.1 дэх заалтын “, 14.1.7” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3.8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**









## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө зарласан тендер шалгаруулалтыг нэмэлт, өөрчлөлт орохын өмнөх зохицуулалтын дагуу зохион байгуулж дуусгана.

**2 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулсан, эсхүл энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тендер шалгаруулалтын дагуу байгуулах худалдан авах гэрээнд гүйцэтгэлийн баталгааны дүнг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.2-т заасантай нийцүүлэн тусгаж болно.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**







## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх, Үндэсний их баяр наадмын хүрээнд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, үндэсний хурдан морины уралдаан, шагайн харвааг зохион байгуулах, цол, чимэг олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Үндэсний их баяр наадмын хууль тогтоомж

2.1.Үндэсний их баяр наадмын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Соёлын өвийг хамгаалах тухай хууль<sup>2</sup>, Биеийн тамир, спортын тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар зохицуулаагүй үндэсний спорттой холбоотой харилцааг Биеийн тамир, спортын тухай хуулиар зохицуулна.

3.2.Үндэсний их баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулахаас бусад үндэсний бөхийн барилдаан, үндэсний хурдан морины уралдаан, сурын болон шагайн харваатай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“Үндэсний их баяр наадам” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баярыг;

4.1.2.“үндэсний спорт” гэж Биеийн тамир, спортын тухай хуулийн 4.1.5-д заасныг;

4.1.3.“допинг” гэж Биеийн тамир, спортын тухай хуулийн 4.1.14-т заасныг;

4.1.4.“Олон улсын допингийн эсрэг агентлаг” гэж Биеийн тамир, спортын тухай хуулийн 4.1.15-д заасныг.

#### **5 дугаар зүйл.Үндэсний их баяр наадам**

5.1.Үндэсний их баяр наадам нь улс, аймаг, сумын баяр наадмаас бүрдэнэ.

5.2.Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадмыг жил бүр Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн<sup>4</sup> 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ.

5.3.Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ зүйлийн 5.2-т зааснаас өөр өдрүүдэд улс, аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх бөгөөд улс, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газар, сумын баяр наадмын хугацааг аймгийн Засаг дарга тогтооно.

5.4.Энэ хуулийн 5.3-т заасан нөхцөлд аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх хугацааг 08 дугаар сарын 10-ны өдрөөс хэтрүүлэхгүй байхаар тогтооно.

5.5.Улсын баяр наадмыг нийслэл хотод, эсхүл Засгийн газраас тогтоосон газарт, аймаг, сумын баяр наадмыг тухайн шатны Засаг даргын тогтоосон газарт тэмдэглэнэ.



5.6. Газар зүйн байршлын хувьд нэг аймгийн зэргэлдээ сумын баяр наадмыг хамтран зохион байгуулан тэмдэглэж болно.

5.7. Улсын баяр наадмаар нийслэлийн алслагдсан дүүргийн баяр наадмыг тусад нь зохион байгуулж болно.

5.8. Энэ хуулийн 5.7-д заасан баяр наадмыг зохион байгуулахад аймгийн баяр наадамтай адилтган үзнэ.

5.9. Улс, аймаг, сумын баяр наадмаар үндэсний бөхийн барилдаан, үндэсний сурын болон шагайн харваа, үндэсний хурдан морины уралдааныг явуулна.

5.10. Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ.

5.11. Хуульд өөрөөр заагаагүй бол улсын баяр наадмаас тусдаа нийслэл хот, дагуул хот, дүүрэг, хороо, баг баяр наадам зохион байгуулахгүй.

5.12. 14-өөс 18 насны өсвөр үеийн үндэсний бөхийн барилдаан болон сурын харвааг Үндэсний их баяр наадмаар зохион байгуулж болно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭ**

### **6 дугаар зүйл. Баяр наадмын нээлт, хаалт**

6.1. Монгол Улсын Төрийн тугийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан журмын дагуу улсын баяр наадмын төв талбайд хүндэтгэн зална.

6.2. Улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11-ний өдөр нээнэ.

6.3. Улсын баяр наадмыг Монгол Улсын Ерөнхийлөгч нээж, хааж үг хэлнэ.

6.4. Монгол Улсын Төрийн тугийг тогтоосон журмын дагуу Төрийн ордонд буцаан зална.

### **7 дугаар зүйл. Төрийн ёслолын бусад арга хэмжээ**

7.1. Улсын баяр наадмын өмнөх өдөр Төрийн далбааны өдөрт зориулсан хүндэтгэл, цэргийн ёслолын жагсаал хийх, Их эзэн Чингис хааны хөшөө, жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд хүндэтгэл үзүүлэн цэцэг өргөх, хүндэтгэлийн концерт тоглох арга хэмжээг зохион байгуулах бөгөөд төр, засгийн удирдлага, улс төрийн нам болон иргэдийн төлөөлөл байлцана.

7.2.Тэгш ой тохиосон бол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан, баярын хурал, ёслолын буудлага хийж болно.

7.3.Улсын баяр наадмыг тохиолдуулан монголын түүх, соёл, ёс заншил, өв уламжлалыг харуулсан урлаг, соёл, спортын арга хэмжээг зохион байгуулж болно.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан арга хэмжээг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо /цаашид “зохион байгуулах хороо” гэх/ төрийн болон бусад байгууллага, хуулийн этгээдийг оролцуулан зохион байгуулж болно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**  
**ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН, ҮНДЭСНИЙ ХУРДАН**  
**МОРИНЫ УРАЛДААН, ҮНДЭСНИЙ СУРЫН БОЛОН**  
**ШАГАЙН ХАРВАА**

**8 дугаар зүйл.Үндэсний бөх, үндэсний хурдан морь, сурын болон шагайн харвааны цол, чимэг**

8.1.Зохион байгуулах хорооны саналыг үндэслэн бөх, сурын болон шагайн харваачид болон энэ хуулийн 10.4-т заасан амжилтыг харгалзан уяачид үндэсний спортын төрлөөр улсын цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч олгоно.

8.2.Энэ хуулийн 14.2-т заасан шинжилгээг өгсөн бөх, сурын харваач допинг хэрэглэсэн нь допингийн шинжилгээгээр тогтоогдсон бол уг шинжилгээний хариу гарсан өдрөөс хойш гурав хоногийн дотор шинжилгээний хариу батламжийг үндэслэн тухайн бөх, харваачид олгосон улсын цолыг хураалгах саналыг зохион байгуулах хороо Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

8.3.Монгол Улсын Ерөнхийлөгч энэ хуулийн 8.2-т заасан саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор зарлиг гаргаж, тухайн бөх, сурын харваачид олгосон улсын цолыг хураана.

8.4.Аймаг, сумын баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн бөх, сурын болон шагайн харваачид аймаг, сумын цолыг аймаг, дүүрэг, сумын Засаг дарга, аймгийн баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн шагайн харваачид үндэсний спортын төрлөөр аймгийн цолыг аймгийн Засаг дарга олгоно.

8.5.Энэ хуулийн 10.5, 10.6-д заасан амжилт, тухайн үндэсний спортын холбоо болон аймаг, сумын баяр наадмыг зохион байгуулах

хорооны саналыг үндэслэн уяачид аймаг, сумын цолыг аймаг, дүүрэг, сумын Засаг дарга олгоно. Энэ хуулийн 5.7, 5.8-д заасан баяр наадамд дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн цолыг Нийслэлийн Засаг дарга олгоно.

8.6.Цолны чимэг, бай шагналыг зохион байгуулах хороо, салбар хороо олгоно.

8.7.Үндэсний их баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан үндэсний хурдан морины уралдаанд энэ хуулийн 10.4-т заасан амжилтыг харгалзан цол, чимэг олгоно.

8.8.Энэ хуулийн 9, 10, 11, 12 дугаар зүйлд заасан цол, чимэг олгох болзол, журмыг хангаагүй бөх, сурын болон шагайн харваач, уяачид цол, чимэг олгохыг хориглоно.

## **9 дүгээр зүйл.Үндэсний бөхийн барилдаан**

9.1.Улсын баяр наадамд 10 жил тутам Их Монгол Улс байгуулагдсаны болон Ардын хувьсгалын тэгш ойг давхцуулан 1024 бөх, бусад баяр наадамд 512 бөх барилдана.

9.2.Улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд барилдах бөх нь 16 насанд хүрсэн байна.

9.3.Улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд дараах амжилт үзүүлсэн бөхөд доор дурдсан улсын цол олгоно:

9.3.1.тав давсан бөхөд улсын начин;

9.3.2.зургаа давсан бөхөд улсын харцага;

9.3.3.долоо давсан бөхөд улсын заан;

9.3.4.найм давсан бөхөд улсын гарьд;

9.3.5.ес давсан бөхөд улсын арслан;

9.3.6.улсын арслан цолтой бөхөөс бага цолтой бөх 10 даван түрүүлсэн бол улсын аварга;

9.3.7.ес даван түрүүлсэн улсын арслан цолтой бөх ес даван үзүүрлэсэн бол улсын аварга;

9.3.8.ес даван түрүүлсэн улсын арслан цолтой бөх 10 даван түрүүлсэн бол даян аварга;



9.3.9.улсын аварга цолтой бөх ес даван үзүүрлэсэн бол даян аварга;

9.3.10.даян аварга цолтой бөх ес даван үзүүрлэхэд дархан аварга;

9.3.11.улсын аварга цолтой бөх 10 даван түрүүлсэн бол дархан аварга.

9.4.Дархан аварга цол нь үндэсний бөхийн дээд цол байна.

9.5.Аймгийн баяр наадамд 16 насанд хүрсэн 128 хүртэлх бөх барилдах бөгөөд тав давсан бөхөд аймгийн начин, үзүүрлэсэн бөхөд аймгийн заан, түрүүлсэн бөхөд аймгийн арслан цол олгоно.

9.6.Сумын баяр наадамд 16 насанд хүрсэн 64 хүртэлх бөх барилдах бөгөөд үзүүрлэсэн бөхөд сумын начин, түрүүлсэн бөхөд сумын заан цол олгоно.

9.7.Үндэсний их баяр наадмын бөхийн барилдаанд барилдах бөхийг үндэс угсаа, төрсөн газар, оршин суугаа засаг захиргааны нэгж, цол, чимгээр нь ялгаварлан барилдах эрхийг хязгаарлахыг хориглоно.

9.8.Улсын баяр наадамд түрүүлсэн, үзүүрлэсэн бөхийн эрэмбийг бөхийн холбооны дүрмээр зохицуулна.

### **10 дугаар зүйл.Үндэсний хурдан морины уралдаан**

10.1.Үндэсний хурдан морины уралдааныг монгол үүлдрийн адууны стандартад нийцсэн морийг азарга, их нас, соёолон, хязаалан, шүдлэн, даага гэсэн зургаан насны ангиллаар зохион байгуулна.

10.2.Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд уралдах морийг найм, түүнээс дээш насны хүүхэд унах бөгөөд уралдаанч хүүхэд нь үндэсний хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан нэг жилийн ослын даатгалд даатгуулсан байна.

10.3.Үндэсний хурдан морины уралдааны явцад хүүхдийг ослын даатгалд даатгуулсан эсэх болон стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглэж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

10.4.Улсын баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан шигшмэл, бүсийн үндэсний хурдан морины уралдаанд морь нь дөрвөн удаа түрүүлсэн, эсхүл найман удаа айрагдсан уяачид улсын алдарт уяач, морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан, үүнээс улсын баяр наадамд нэг түрүүлсэн, эсхүл хоёр удаа айрагдсан уяачид улсын манлай уяач, морь нь 10 удаа түрүүлсэн, эсхүл 20 удаа айрагдсан, үүнээс улсын баяр наадамд хоёр удаа түрүүлсэн, эсхүл дөрвөн удаа айрагдсан уяачид улсын тод манлай уяач цол олгоно.

10.5.Аймгийн баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид аймгийн алдарт уяач цол олгоно.

10.6.Сумын баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морь нь зургаан удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид сумын алдарт уяач цол олгоно.

10.7.Улс, аймаг, сумын цол олгох уяачийн морины 50, түүнээс дээш хувь нь азарга, их насны ангилалд улс, аймгийн баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр хийж байгаа шигшмэл, бүсийн уралдааны үндэсний хурдан морины уралдаанд түрүүлсэн, айрагдсан байна.

10.8.Уяачид улс, аймаг, сумын цолыг жил бүрийн цагаан сарын баяраар олгоно.

10.9.Энэ хуулийн 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасны дагуу уяачийн амжилтыг тооцож, цол олгохдоо тухайн уралдааныг зохион байгуулж байгаа үндэсний хурдан морины салбар хороонд уяачаар бүртгүүлсэн иргэний амжилтад тооцон уг цолыг олгох бөгөөд түрүүлсэн, айрагдсан нэг морины нэг удаагийн амжилт нь зөвхөн энэ зүйлд заасан нэг уяачид цол олгох үндэслэл болно.

10.10.Улсын баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд зургаагаас 10 дугаар байр эзэлсэн бүх насны морийг улсын баяр наадмын хурдан морины салбар хороо орон даяар нийтэд зарлана.

10.11.Үндэсний хурдан морины бүртгэл нь Малын генетик нөөцийн тухай хуулийн<sup>5</sup> 5.7-д заасан нэгдсэн сангийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд бүртгэлийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хурдан морины чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгэнэ.

10.12.Хурдан морины уралдааны салбар хорооны морины бүртгэлийн дэд хороо нь улсын баяр наадам эхлэхээс гурав, аймагт хоёр хүртэлх өдрийн өмнө энэ хуулийн 10.11-д заасан мэдээллийн санд орсон, монгол үүлдрийн адууны стандартын шаардлагад нийцсэн морийг Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд уралдах мориор бүртгэнэ.

10.13.Энэ хуулийн 10.1, 13.2-т заасан стандартын шаардлага хангаагүй морийг бүртгэхийг хориглоно.

10.14.Энэ хуулийн 10.12-т заасан бүртгэлийн явц болон бүртгүүлсэн морины талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хэлбэрээр ил тод, нээлттэй явуулна.

10.15.Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд уралдах морийг уралдааны өдөр энэ хуулийн 10.12-т заасан бүртгэлтэй тулгаж, нийцсэн тохиолдолд уралдуулна.

10.16.Энэ хуулийн 10.12-т заасан бүртгэлд бүртгүүлээгүй, эсхүл бүртгэхээс татгалзсан морийг Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд уралдуулах, барианд барихыг хориглоно.

10.17.Энэ хуульд зааснаас бусад нөхцөлөөр Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морийг бүртгэхээс татгалзах, бүртгэл болон уралдаанаас хасах, цол, чимэг олгохоос татгалзах, олгосон цол, чимгийг хураахыг хориглоно.

10.18.Засгийн газрын шийдвэрээр нэгэн зэрэг дөрөв хүртэл бүсэд хурдан морины шигшмэл, бүсийн уралдааныг зохион байгуулж болно.

10.19.Үндэсний их баяр наадмаар жороо морины уралдааныг зохион байгуулж болно.

## **11 дүгээр зүйл. Үндэсний сурын харваа**

11.1.Улсын баяр наадмын үндэсний сурын харвааг үндэсний их сурын цуваа харваагаар явуулна. Үндэсний сурын харваач нь 18 насанд хүрсэн байна.

11.2.Улсын баяр наадмын үндэсний сурын харваанд тавдугаар байр эзэлсэн харваачид улсын тод харваач, дөрөвдүгээр байр эзэлсэн харваачид улсын онч харваач, гуравдугаар байр эзэлсэн харваачид улсын гоц харваач, хоёрдугаар байр эзэлсэн харваачид улсын гарамгай харваач, нэг түрүүлсэн харваачид улсын мэргэн, улсын мэргэн цолтон түрүүлсэн





бол улсын даян мэргэн, улсын даян мэргэн цолтон түрүүлсэн бол улсын даяар дуурсах мэргэн, улсын даяар дуурсах мэргэн цолтон түрүүлсэн бол улсын дархан мэргэн цол олгоно.

11.3.Аймгийн баяр наадмын үндэсний сурын харваанд түрүүлсэн харваачид аймгийн мэргэн, хоёрдугаар байр эзэлсэн харваачид аймгийн гарамгай харваач, гуравдугаар байр эзэлсэн харваачид аймгийн гоц харваач, дөрөвдүгээр байр эзэлсэн харваачид онч харваач, тавдугаар байр эзэлсэн харваачид тод харваач цол олгоно.

11.4.Сумын баяр наадмын үндэсний сурын харваанд гуравдугаар байр эзэлсэн харваачид сумын гоц харваач, хоёрдугаар байр эзэлсэн харваачид сумын гарамгай харваач, түрүүлсэн харваачид сумын мэргэн цол олгоно.

11.5.Энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр сурын харваачийг Үндэсний их баяр наадмын үндэсний сурын харваанд бүртгэхээс татгалзах, бүртгэлээс хасах, сурын харваанаас хасах, цол, чимэг олгохоос татгалзах, олгосон цол, чимгийг хураахыг хориглоно.

## **12 дугаар зүйл. Үндэсний шагайн харваа**

12.1.Үндэсний шагайн харвааг багийн харваагаар явуулна.

12.2.Үндэсний шагайн харвааны баг тус бүр найман харваачтай байна.

12.3.Үндэсний шагайн харвааны багийн харваач нь 18 насанд хүрсэн байна.

12.4.Улсын баяр наадмын шагайн харваанд эхний гурван байрт нэг удаа шалгарсан багийн харваачид улсын мэргэн, хоёр дахь удаагаа шалгарсан багийн харваачид улсын хошой мэргэн цол олгоно.

12.5.Улсын баяр наадмын шагайн харваанд улсын хошой мэргэн цолтой харваач түрүүлсэн бол улсын гарамгай мэргэн, улсын гарамгай мэргэн цолтой харваач түрүүлсэн бол улсын дархан мэргэн, улсын дархан мэргэн цолтой харваач түрүүлсэн бол улсын үлэмж дархан мэргэн цол олгоно.

12.6.Улсын баяр наадмын шагайн харваанд 10 ба түүнээс дээш удаа түрүүлсэн харваачид улсын даяар дуурсагдах дархан мэргэн цол олгоно.

12.7.Аймгийн баяр наадмын үндэсний шагайн харваанд эхний гурван байрт гурван удаа шалгарсан бол аймгийн хошой мэргэн, таван удаа шалгарсан бол аймгийн гоц мэргэн цол олгоно.

12.8.Шагайн харваачид сумын цол олгож болно.

12.9.Шагайн харваачид улс, аймгийн цолыг жил бүрийн цагаан сарын баяраар олгоно.

### **13 дугаар зүйл.Үндэсний бөх, хурдан морь, сурын болон шагайн харвааны стандарт**

13.1.Үндэсний их баяр наадмын үндэсний бөх, сурын болон шагайн харваа, үндэсний хурдан морины уяачийн эд хэрэглэл, уралдаанч хүүхдийн хувцас, морины хэрэгсэлд тавигдах стандартыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох үндэсний спортын холбооны саналыг үндэслэн боловсруулж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

13.2.Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд уралдах монгол үүлдрийн адууны стандартыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох үндэсний спортын холбооны саналыг үндэслэн боловсруулж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

Тайлбар:Энэ хуулийн 13.1-д заасан “үндэсний бөх, сурын болон шагайн харваа, морь, үндэсний хурдан морины уяачийн эд хэрэглэл, уралдаанч хүүхдийн хувцас, морины хэрэгсэл” гэж үндэсний бөхийн малгай, зодог шуудаг, гутал, үндэсний сур харвааны нум, сум, харваачийн малгай, хурдан морины уяачийн малгай, уралдаанч хүүхдийн ташуур, цулбуур, хамгаалалтын хувцас, шагайн харваачийн малгай, шагайн харвааны шагай, хасаа, аравч болон бусад эд зүйлийг ойлгоно.

### **14 дүгээр зүйл.Үндэсний их баяр наадамд оролцож байгаа бөх, уяач, сурын болон шагайн харваач, дасгалжуулагч, эмчийн эрх, үүрэг**

14.1.Үндэсний их баяр наадамд оролцож байгаа бөх, уяач, харваач нь наадамчин олон, баяр наадмаа хүндэтгэн, төрийн ёслол, зан уламжлалыг чанд сахина.

14.2.Энэ хуулийн 9.1-д заасан бөхийн барилдаанд дөрөв, түүнээс дээш давсан бөх, 11.2-т заасан үндэсний сурын харвааны эрэгтэй болон эмэгтэй тус бүр эхний найман байр эзэлсэн харваачаас допингийн шинжилгээ авна.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан этгээд допингийн шинжилгээнд орохоос татгалзсан, зайлсхийсэн бол допинг хэрэглэсэнд тооцно.

14.4.Үндэсний их баяр наадмын бөхийн барилдаанд барилдах бөх дараах эрх эдэлнэ:

14.4.1.улс, аймаг, сумын цол авах;

14.4.2.Үндэсний их баяр наадмын үед гарсан маргааны шийдвэрийн талаар энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу гомдол гаргах;

14.4.3.үндэсний бөхийн барилдааны дүрэмд заасан бусад эрх.

14.5.Үндэсний их баяр наадмын бөхийн барилдаанд барилдах бөх дараах үүрэг хүлээнэ:

14.5.1.хууль, дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

14.5.2.Монгол Улсын стандартад нийцсэн бөхийн малгай, зодог шуудаг, гутал, хүлэг боолтыг өмсөж барилдах;

14.5.3.барилдааны үед засуул, хөлийн цэцийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

14.5.4.хориотой, учраа бөхөө гэмтээх барьц барихгүй, хөдөлгөөн хийхгүй байх;

14.5.5.эрүүл мэндийн зайлшгүй шалтгааны улмаас Олон улсын допингийн эсрэг агентлагаас жил бүр баталсан Хориглосон жагсаалтад багтсан бодис, аргыг хэрэглэх тохиолдолд энэ тухай Эмчилгээний зорилгоор чөлөөлөх Олон улсын стандартад заасны дагуу Допингийн эсрэг үндэсний байгууллагад хандах;

14.5.6.Дэлхийн допингийн эсрэг агентлагаар итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтээр хориглосон бодис, арга хэрэглэсэн нь илэрсэн бөх, харваач "В" дээжид шинжилгээ хийлгэх бол уг шинжилгээний төлбөрийг төлөх;

14.5.7.энэ хуулийн 14.5.2, 14.5.3, 14.5.4, 14.5.5-д заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд улсын цол, чимгээ хураалгаж, хуульд заасан хариуцлага хүлээхэд татгалзах зүйлгүй талаарх баталгааг бичгээр гаргаж, салбар хороонд өгөх;

14.5.8.хууль, дүрэмд заасан бусад үүрэг.

14.6.Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морио уралдуулах уяач дараах эрх эдэлнэ:

14.6.1.улс, аймаг, сумын цол авах;

14.6.2.Үндэсний их баяр наадмын үед гарсан маргааны шийдвэрийн талаар энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу гомдол гаргах;

14.6.3.үндэсний хурдан морины уралдааны дүрэмд заасан бусад эрх.

14.7.Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд морио уралдуулах уяач дараах үүрэг хүлээнэ:

14.7.1.хууль, дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

14.7.2.эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

14.7.3.энэ хуулийн 10.1-д заасан шаардлагыг хангасан байх;

14.7.4.морийг насны өөр ангилал болон энэ хуулийн 10.13-т заасан шаардлага хангаагүй морийг Үндэсний их баяр наадамд уралдуулахгүй байх;

14.7.5.энэ хуулийн 10.12-т заасан хугацаанд бүртгэлд хурдан морио бүртгүүлсэн байх;

14.7.6.хурдан морийг дагахгүй, зориуд хөөхгүй байх;

14.7.7.уралдаанч хүүхдэд энэ хуулийн 13.1-д заасан стандартын шаардлагад нийцсэн хувцас, хэрэглэл хэрэглүүлэх;

14.7.8.уралдаанч хүүхэд болон бусад уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд эрсдэлтэй нөхцөлийг үүсгэхгүй байх, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц эд зүйлийг үндэсний хурдан морины уралдаан болон морины сунгаа, бэлтгэлийн үед хэрэглүүлэхгүй байх;

14.7.9.уралдаанч хүүхдийг Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаан болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан нэг жилийн хугацаатай ослын даатгалд даатгуулсан байх;

14.7.10.уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангах, учирсан хохирлыг нөхөн төлөх;

14.7.11.уралдаанч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаан болон морины сунгаа, бэлтгэлийн үед морь унуулах зөвшөөрлийг бичгээр авсан байх;

14.7.12.үндэсний хурдан морины уралдааны дүрэмд заасан бусад үүргийг биелүүлэх.

14.8.Үндэсний их баяр наадмын үндэсний сурын болон шагайн харваанд оролцох сурын болон шагайн харваач дараах эрх эдэлнэ:

14.8.1.улс, аймаг, сумын цол авах;

14.8.2.баяр наадмын үед гарсан маргааны шийдвэрийн талаар энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу гомдол гаргах;

14.8.3.үндэсний сурын харвааны дүрэм болон үндэсний шагайн харвааны дүрэмд заасан бусад эрх.

14.9.Үндэсний их баяр наадмын үндэсний сурын болон шагайн харваанд оролцож байгаа сурын болон шагайн харваач дараах үүрэг хүлээнэ:

14.9.1.хууль, дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

14.9.2.стандартын шаардлагад нийцсэн эд хэрэглэл хэрэглэх;

14.9.3.шүүгчийн шаардлагыг биелүүлэх;

14.9.4.үндэсний сурын харвааны дүрэм болон үндэсний шагайн харвааны дүрэмд заасан бусад үүргийг биелүүлэх;

14.9.5.ёс зүй, сахилга, хариуцлагын дүрмийг чанд мөрдөх.

14.10.Үндэсний бөх, сурын харваачийн дасгалжуулагч, эмч дараах үүрэг хүлээнэ:

14.10.1.дасгалжуулж байгаа үндэсний бөх, сурын харваачид допинг хэрэглэхийг санал болгохгүй, допинг хэрэглүүлэхгүй байх;

14.10.2.хууль, дүрэмд заасан бусад.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

### **15 дугаар зүйл. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах талаарх Засгийн газрын бүрэн эрх**

15.1. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1. үндэсний бөхийн барилдаан, үндэсний хурдан морины уралдаан, сурын болон шагайн харвааны дүрмийг батлах;

15.1.2. улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх төрийн ёслолын арга хэмжээний журмыг батлах;

15.1.3. зохион байгуулах хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах;

15.1.4. улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх, допингийн шинжилгээ хийхэд шаардагдах төсвийг батлах, зарцуулалтад хяналт тавих;

15.1.5. бөх, уяач, харваач, үндэсний хурдан морины уралдаанд оролцсон хүүхдэд олгох бай, шагналын хэмжээг тогтоох;

15.1.6. Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагаар допингийн шинжилгээ хийлгэх арга хэмжээг зохион байгуулуулах;

15.1.7. Үндэсний их баяр наадам өөрийн бэлгэдэл /барааны тэмдэг/-тэй байх бөгөөд хэрэглэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан батлах.

15.2. Засгийн газар энэ хуулийн 15.1.1-д заасан дүрмийг батлахдаа холбогдох үндэсний спортын холбооны саналыг авсан байна.

15.3. Энэ хуулийн 15.1.1-д заасан дүрэм нь бөх, уяач, сурын болон шагайн харваач, хурдан морины бүртгэх, эрэмблэх, өсвөр үеийн бөхийн насны дээд, доод хязгаар, оролцогчийн эрх, үүрэг, ёс зүй, сахилга, хариуцлага, маргаан шийдвэрлэлт, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалт, мэдээллийн сан хөтлөх болон бусад үндэсний бөхийн барилдаан, сурын болон шагайн харваа, үндэсний хурдан морины уралдааныг зохион байгуулахтай холбогдох бусад зохицуулалтыг агуулна.

## **16 дугаар зүйл. Зохион байгуулах хороо, түүний бүрэн эрх**

16.1. Үндэсний их баяр наадмыг уламжлалт ёс заншил, өв соёлд тулгуурлан улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах хороо, аймаг, сумын хороо хариуцна. Зохион байгуулах хороо холбогдох үндэсний спортын холбоотой хамтран Үндэсний их баяр наадмыг зохион байгуулж болно.

16.2. Зохион байгуулах хороо нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

16.3. Зохион байгуулах хороо албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэх бөгөөд хэлэлцсэн асуудлаараа олонхын саналаар тогтоол, зохион байгуулах хорооны дарга энэ хууль болон дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор тушаал гаргана.

16.4. Зохион байгуулах хорооны дарга нь Монгол Улсын Шадар сайд, дэд дарга нь Нийслэлийн Засаг дарга байна.

16.5. Зохион байгуулах хороо нь улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.5.1. улсын баяр наадмыг зохион байгуулах;

16.5.2. улсын баяр наадамд үзүүлсэн амжилтыг үндэслэн бөх, сурын болон шагайн харваачид үндэсний спортын төрлөөр улсын цол олгох, хасах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх;

16.5.3. энэ хуулийн 10.4-т заасан амжилтыг үндэслэн уяачид цол олгох, хасах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх;

16.5.4. өсвөр үеийнхний бөхийн барилдаан болон үндэсний сурын харвааг зохион байгуулах, өсвөр үеийн бөх, харваач, үндэсний хурдан морины уралдаанд оролцсон хүүхдэд үндэсний спортын холбооны саналыг үндэслэн цол олгох;

16.5.5. улсын баяр наадмын үеэр урлагийн тоглолт, спорт, биеийн тамирын тэмцээн, ардын уламжлалт тоглоом, наадгай, нийтийн цэнгүүн зохион байгуулах;

16.5.6. бөх, уяач, сурын болон шагайн харваачид бай, шагнал олгох;



16.5.7.бөх, сурын харваачийг энэ хуулийн 14.2-т заасан допингийн шинжилгээнд оруулах ажлыг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагаар зохион байгуулуулах;

16.5.8.улсын баяр наадмын төсвийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлэх;

16.5.9.бөх, морь, сурын болон шагайн харваачийн салбар хороо, бүртгэлийн дэд хороо байгуулах, түүний бүрэлдэхүүн, дүрмийг батлах;

16.5.10.аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх нийтлэг журмыг баталж, мөрдүүлэх;

16.5.11.Үндэсний их баяр наадмын түүхэн хөгжил, үндэсний бөх, сурын болон шагайн харваач, үндэсний хурдан морины уяачийн цол, чимэг, эрэмбэ, зөрчлийн мэдээллийг агуулсан цахим мэдээллийн сан үүсгэх, хөтлөх, нийтэд тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулах;

16.5.12.энэ хуулийн 15.1.1-д заасан бөх, уяач, сурын болон шагайн харваач, дасгалжуулагчийн ёс зүй, сахилга, хариуцлагын асуудлыг тусгасан дүрмийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, зөрчлийн талаарх мэдээллийн нэгдсэн сан бий болгох, бүртгэл хөтлөх;

16.5.13.улсын баяр наадмыг зохион байгуулахтай холбогдуулан төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдийн өөрийнх нь зөвшөөрлийн дагуу татан оролцуулах, дэмжлэг туслалцаа авах, ажлын хэсэг, алба байгуулах зэргээр хамтран ажиллах;

16.5.14.энэ хууль болон дүрэмд заасан зарим бүрэн эрхийг зохион байгуулах хорооны даргад тодорхой хугацаагаар шилжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

16.5.15.зохион байгуулах хорооны дүрэмд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

16.6.Зохион байгуулах хороог зохион байгуулах хорооны дарга төлөөлөх бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтантай холбогдох хууль тогтоомжийн дагуу харилцана.

16.7.Зохион байгуулах хороо нь салбар хороотой байна. Салбар хороо нь дэд хороотой байж болно.



16.8.Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдааны морины бүртгэлийн дэд хороо нь 19 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд уг бүрэлдэхүүнд холбогдох төрийн байгууллага, эрдэмтэн, судлаач, холбоо, байгууллагын төлөөлөл орно.

16.9.Энэ хуулийн 16.5.3, 16.5.5, 16.5.6, 16.5.10-т заасан бүрэн эрх болон улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаан, үндэсний хурдан морины уралдаан, сурын болон шагайн харвааг зохион байгуулах эрхийг тухайн салбар хорооны саналыг үндэслэн зохион байгуулах хорооны шийдвэрээр холбогдох үндэсний спортын холбоонд шилжүүлж болно.

16.10.Энэ хуулийн 16.9-д заасны дагуу бүрэн эрхийг шилжүүлсэн тохиолдолд тухайн үндэсний спортын холбоо энэ хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, журамд заасан салбар хорооны чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### **17 дугаар зүйл.Аймаг, сумын баяр наадмыг зохион байгуулах талаарх Засаг даргын бүрэн эрх**

17.1.Аймаг, сумын баяр наадмыг зохион байгуулах талаар аймаг, сумын Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах;

17.1.2.энэ хуулийн 16.5.9-д заасан нийтлэг журмын хүрээнд баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх үүрэг бүхий аймаг, сумын хорооны бүрэлдэхүүн, дүрмийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан мөрдөх;

17.1.3.энэ хуулийн 8.4-т заасан саналыг үндэслэн бөх, сурын болон шагайн харваачид, уяачид үндэсний спортын төрлөөр аймаг, сумын цол олгох, хүчингүй болгох;

17.1.4.аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан зарцуулах;

17.1.5.Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаан болон бусад сунгаа, бэлтгэлийн үед хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор уг нөхцөлийг үүсгэж байгаа үйл ажиллагааг хязгаарлах, хориглох арга хэмжээг авах, хяналт тавих.

## **18 дугаар зүйл. Допингийн эсрэг үйл ажиллагаа**

18.1. Олон улсын допингийн эсрэг агентлагаас жил бүр баталсан допингийн хориглосон жагсаалтад багтсан бодис, аргыг үндэсний бөх, сурын харваач хэрэглэхийг хориглоно.

18.2. Бөх, сурын харваач, холбогдох үндэсний спортын холбоо Дэлхийн допингийн эсрэг дүрэм, эсхүл Допингийн эсрэг үндэсний дүрмийг тамирчны нэгэн адил дагаж мөрдөнө.

18.3. Энэ хуулийн 14.2-т заасан бөх, сурын харваачаас допингийн шинжилгээ авах арга хэмжээг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага зохион байгуулна.

18.4. Бөх болон сурын харваач допингийн төрлийн бодис хэрэглэсэн бол Үндэсний их баяр наадамд барилдах бөх, сурын харваачийн харвах эрхийг энэ хуулийн 18.2-т заасан дүрмийн дагуу хасна.

18.5. Энэ хуулийн 14.2-т заасан шинжилгээгээр бөх, сурын харваач допинг хэрэглэсэн нь тогтоогдсон бол тухайн баяр наадамд олгосон цол, чимэг, байрыг хурааж, тухайн даваанд унасан бөх, удаалсан сурын харваачид улсын цолыг нөхөн олгох саналыг зохион байгуулах хороо Монгол Улсын Ерөнхийлөгчид гаргана.

18.6. Монгол Улсын Ерөнхийлөгч энэ хуулийн 18.5-д заасан саналыг хүлээж авснаас хойш 7 хоногийн дотор улсын цол, байрыг олгохгүй байх, эсхүл хасах, эсхүл нөхөн олгох шийдвэр гаргана.

18.7. Энэ хуулийн 14.2-т заасан шинжилгээгээр бөх, сурын харваач допинг хэрэглэсэн нь тогтоогдсон бол тухайн бөх, сурын харваачийн Үндэсний их баяр наадамд оролцох эрхийг энэ хуулийн 18.4-т заасан хугацаагаар хасах саналыг салбар хороо зохион байгуулах хороонд гаргаж, шийдвэрлүүлнэ.

18.8. Энэ хуулийн 14.2-т заасан шинжилгээгээр бөх, сурын харваач допинг хэрэглэсэн нь тогтоогдсон бол тухайн бөх, сурын харваачийн дасгалжуулагчийн эрхийг хоёр жилийн хугацаанд түдгэлзүүлэх саналыг зохион байгуулах хороо эрх бүхий этгээдэд гарган шийдвэрлүүлнэ.

18.9. Энэ хуулийн 18.4-т заасан шийдвэр гарсан бол тухайн даваанд унасан бөх, удаалсан сурын харваачид улсын цол, чимгийг нөхөн олгоно.

## ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

### 19 дүгээр зүйл.Хариуцлага

19.1.Энэ хууль болон холбогдох дүрэм, журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд<sup>6</sup> заасан хариуцлагаас гадна зохион байгуулах хороо дараах хариуцлагыг хүлээлгэнэ:

19.1.1.Үндэсний их баяр наадмын тухайн үндэсний бөхийн барилдаан, үндэсний хурдан морины уралдаан, үндэсний сур болон шагайн харваанаас хасах;

19.1.2.тухайн баяр наадмын бай, шагналыг олгохгүй байх;

19.1.3.энэ хуульд заасан журмыг зөрчиж бөх, уяач, сурын болон шагайн харваачид цол, чимэг олгосон бол олгосон цол, чимгийг хураах, олгосон эрх бүхий албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд<sup>7</sup> заасан арга хэмжээг авах.

19.2.Уралдаанч хүүхдэд энэ хуулийн 13.1-д заасан стандартын шаардлага хангаагүй хэрэглэл хэрэглүүлсэн хурдан морины уяачийг Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаанд нэг жилийн хугацаанд морио бүртгүүлэх, уралдуулахгүй байх саналыг салбар хороо зохион байгуулах хороонд хүргүүлж, мэдээллийн санд оруулж, шийдвэрлүүлнэ.

### 20 дугаар зүйл.Маргаан шийдвэрлэх

20.1.Улсын баяр наадам болон аймгийн баяр наадмын үндэсний хурдан морины уралдааны бүртгэлтэй холбоотой маргааныг дээд шатны хороо хоёр хоногийн дотор шийдвэрлэнэ.

20.2.Сумын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл аймгийн хороонд, аймгийн болон салбар хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл зохион байгуулах хороонд гомдол гаргана.

20.3.Зохион байгуулах хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

## 21 дүгээр зүйл. Шилжилтийн үеийн зохицуулалт

21.1. Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө үндэсний спортын төрлөөр бөх, сурын болон шагайн харваач, уяачид олгосон улс, аймаг, сумын цол хүчин төгөлдөр байна.

21.2. 2003 оноос өмнө олгосон бөхийн цол, амжилтын эрэмбийг Монголын үндэсний бөхийн холбоо тогтооно.

21.3. Монгол үүлдрийн адууны стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулах хүртэл хугацаанд Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдааныг энэ хуулийн 15.1.1-д заасны дагуу Засгийн газраас баталсан дүрмээр зохицуулна.

21.4. Энэ хуулийн 10.11-д заасан бүртгэлд адуун сүргийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор бүртгүүлэх ажлыг Засгийн газар зохион байгуулна.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

### Г.ЗАНДАНШАТАР

### Зөвшөөрөгчид

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



Т1 КМШН НХЛГ .. тэвчин хэл мэндэгчээрэ релхнэ г

Т1 . тэвчин тэн хэлтэстэйтэ г мэрэн мэдгээр г релхэг тэн тэвчээрэн тэдэгчээрэ г хн он г хэл тэвчин . релхэг мр тэвчин тэвчин он нэрлэгчээрэ г ..

Т1 . мэдгээр г хнэ гтэн нэлхээр тэйвэр хэвэр мр тэгэн мр тэлхээр гтэнгээр г мэр мэдгээр г релхэг г хнэ гтэдэгчээрэ . мэдгээр г тэлхэгчээрэ г тэн мр тэлхэгчээрэ г тэн мр тэлхэгчээрэ г тэн мр тэлхэгчээрэ г тэн мр тэлхэгчээрэ г тэн мр тэлхэгчээрэ г тэн мр тэлхэгчээрэ г ..

р керэн хэлгэ .. тэвчин хэл тэн г тэвчээр г мэгчтэвчээрэ г

р . тэвчин хэлтэвчээрэ мэгчтэвчээрэ тэн г тэвчин г хн тэмгэ г мэгчтэвчээрэ тэмээр г тэн мэгчтэвчээрэ г :

р . тэвчин « мэдгээр г хнэ гтэн нэлхээр тэйвэр хэвэр мр тэгэн мр тэлхээр гтэнгээр » релхэгчээрэ тэвчээр мр тэлхээр тэмгээр г релхэгчээрэ г хнэ гтэдэгчээрэ г хнэ гтэн нэлхээр тэйвэр хэвэр мр тэлхээр гтэнгээр » хэлгэгчээрэ г хнэ гтэн нэлхээр тэйвэр хэвэр мр тэлхээр гтэнгээр г ..

р . тэвчин « мэдгээр г релхэгчээрэ » релхэгчээрэ мр тэлхээр тэвчин хэл тэвчээрэ гтэн мэдгээр тэмгээр гтэн гтэн мэдгээр гтэн гтэн мэдгээр гтэн г ..

р . тэвчин « мэдгээр г релхэгчээрэ » релхэгчээрэ мр тэлхээр тэвчин хэл тэвчээрэ гтэн мэдгээр тэмгээр гтэн гтэн мэдгээр гтэн гтэн мэдгээр гтэн г ..

р . тэвчин « мэдгээр тэмгээр мр мэдгээр г релхэгчээрэ » релхэгчээрэ мр тэлхээр тэвчин хэл тэвчээрэ гтэн мэдгээр тэмгээр гтэн гтэн мэдгээр гтэн гтэн мэдгээр гтэн г ..

р . тэвчин хэлгэ .. мэдгээр г хнэ гтэн нэлхээр г

р . тэвчин хэлтэвчээрэ г хнэ гтэн нэлхээр тэйвэр хэвэр мр тэгэн мр тэлхээр гтэнгээр » релхэгчээрэ г хнэ гтэдэгчээрэ г ..

р . тэвчин хэлтэвчээрэ г хнэ гтэн нэлхээр тэйвэр хэвэр мр тэгэн мр тэлхээр гтэнгээр » релхэгчээрэ г хнэ гтэдэгчээрэ г ..

р . тэвчин хэлтэвчээрэ г хнэ гтэн нэлхээр тэйвэр хэвэр мр тэгэн мр тэлхээр гтэнгээр » релхэгчээрэ г хнэ гтэдэгчээрэ г ..















66. 06 - Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..

66. 06 . Үүс хэргийн үндэслэлээр үргэлжлэн үргэлжлүүлж байна. Үндэслэлээр үргэлжлүүлж байна. ..













᠗᠐. ᠗. ᠐᠖ . бэрэгдэн хам бүтээгдэхүүнийг хэн өгснийгээр  
᠑. ᠗. ᠐᠖ . хамгаалсан үйлдвэр, хамгаалсан үйлдвэр хэргийг хэлж үзэхийг үгүйсгэн хэлж болно.

Угсаа, бэлчээл.

᠒᠐. ᠗. ᠐᠖ . хувиар хуваах, хувиар хуваах үйлдвэр, хувиар хуваах үйлдвэр.

᠒᠐᠖. ᠐᠖ . хамгаалсан үйлдвэр, хамгаалсан үйлдвэр, хамгаалсан үйлдвэр, хамгаалсан үйлдвэр, хамгаалсан үйлдвэр.

᠒᠐᠖. ᠐᠖. ᠐᠖ . хамгаалсан үйлдвэр, хамгаалсан үйлдвэр, хамгаалсан үйлдвэр, хамгаалсан үйлдвэр, хамгаалсан үйлдвэр.  
Угсаа, бэлчээл, үйлдвэр, үйлдвэр.

᠒᠐. ᠒᠐᠖. ᠐᠖ . үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.

Хамгаалсан үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.

᠒᠐᠖. ᠒᠐᠖. ᠒᠐᠖ . үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.

᠒᠐᠖. ᠒᠐᠖. ᠒᠐᠖ . үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.

᠒᠐᠖. ᠒᠐᠖. ᠒᠐᠖ . үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.  
Хамгаалсан үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.

᠒᠐᠖. ᠒᠐᠖. ᠒᠐᠖ . үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.

᠒᠐᠖. ᠒᠐᠖. ᠒᠐᠖ . үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.

᠒᠐᠖. ᠒᠐᠖. ᠒᠐᠖ . үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.  
Хамгаалсан үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр.



















**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ  
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД  
ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2003 оны 06 дугаар сарын 19-ний өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийг хүчингүйд болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Хүчингүйд болсон хууль

Хүчингүйд болсон хууль 2003 оны 06 дугаар сарын 19 - өдөр

Хүчингүйд болсон хууль 2003 оны 06 дугаар сарын 19 - өдөр

Хүчингүйд болсон хууль 2003 оны 06 дугаар сарын 19 - өдөр

Хүчингүйд болсон хууль 2003 оны 06 дугаар сарын 19 - өдөр

Хүчингүйд болсон хууль 2003 оны 06 дугаар сарын 19 - өдөр



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
ХОТ

## НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “Үндэсний” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, мөн заалтын “11” гэсний өмнө “10,” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Хуульчилсан үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/ 2022 оны 06 сарын 28-ны өдөр баталсан

Улаанбаатар хот, дүүрэг 10-ийн 1-дүгээр хороо, Төрийн мэдээлэл агентлагийн байр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
ЭНЭ ХУУЛЬД ӨӨРӨӨР ЗААГААГҮЙ БОЛ ГЭЖ, МӨН ЗААЛТЫН “11” ГЭСНИЙ  
ӨМНӨ “10,” ГЭЖ ТУС ТУС НЭМСҮГЭЙ.

ЭНЭ ХУУЛИЙГ ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГА/ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛСОН ӨДРӨӨС ЭХЛЭН ДАГАЖ МӨРДӨНӨ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУльд НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “онцлог шинжийг агуулсан” гэсний дараа “үндэсний бөхийн барилдаан, сур, шагайн харваа, хурдан морины уралдаан зэрэг үндэсний уламжлалт” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Биеийн тамир, спортын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “Допингийн” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол допингийн” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Урьдчилж үзсэн

2022 оны 06 сарын 28 - өдөр  
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Урьдчилж үзсэн  
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

6 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “онцлог шинжийг агуулсан” гэсний дараа “үндэсний бөхийн барилдаан, сур, шагайн харваа, хурдан морины уралдаан зэрэг үндэсний уламжлалт” гэж нэмсүгэй.

7 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “Допингийн” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол допингийн” гэж өөрчилсүгэй.

Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Урьдчилж үзсэн  
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн Зургадугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 6.28 дугаар зүйл нэмсүгэй:

#### **“6.28 дугаар зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хууль зөрчих**

1.Үндэсний бөх, сурын болон шагайн харваа, хурдан морины дүрмийг бөх, уяач, сурын болон шагайн харваач, дасгалжуулагч, эмч зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Үндэсний их баяр наадамд барилдах бөх, сурын харваачид допинг хэрэглэхийг зөвлөсөн, шаардсан, хэрэглүүлсэн бол дасгалжуулагч, эмч, дэвжээ, галын тэргүүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Бөх, сурын харваач допинг хэрэглэсэн бол тухайн бөх, сурын харваачийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хурдан морины уралдаанд уралдаанч хүүхдэд болон бусад хүүхдийн аюулгүй байдалд эрсдэлтэй нөхцөлийг үүсгэж, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц эд зүйл хэрэглүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж уяачийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан шаардлагыг хангаагүй морийг бүртгүүлсэн бол уяачийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**







**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2022 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
ХОТ

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 13.1.9 дэх заалт нэмсүгэй:

“13.1.9.хүүхдийг эрсдэлтэй нөхцөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор уг нөхцөлийг үүсгэж байгаа үйл ажиллагааг хязгаарлах, хориглох арга хэмжээг авах.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**Хүчин гүйцэтгэх журмын тухай**

Хүчин гүйцэтгэх журмын тухай хуулийн 70 - ө, 71 - ө, 72 - ө, 73 - ө, 74 - ө, 75 - ө, 76 - ө, 77 - ө, 78 - ө, 79 - ө, 80 - ө, 81 - ө, 82 - ө, 83 - ө, 84 - ө, 85 - ө, 86 - ө, 87 - ө, 88 - ө, 89 - ө, 90 - ө, 91 - ө, 92 - ө, 93 - ө, 94 - ө, 95 - ө, 96 - ө, 97 - ө, 98 - ө, 99 - ө, 100 - ө

Хүчин гүйцэтгэх журмын тухай хуулийн 70 - ө, 71 - ө, 72 - ө, 73 - ө, 74 - ө, 75 - ө, 76 - ө, 77 - ө, 78 - ө, 79 - ө, 80 - ө, 81 - ө, 82 - ө, 83 - ө, 84 - ө, 85 - ө, 86 - ө, 87 - ө, 88 - ө, 89 - ө, 90 - ө, 91 - ө, 92 - ө, 93 - ө, 94 - ө, 95 - ө, 96 - ө, 97 - ө, 98 - ө, 99 - ө, 100 - ө

Хүчин гүйцэтгэх журмын тухай хуулийн 70 - ө, 71 - ө, 72 - ө, 73 - ө, 74 - ө, 75 - ө, 76 - ө, 77 - ө, 78 - ө, 79 - ө, 80 - ө, 81 - ө, 82 - ө, 83 - ө, 84 - ө, 85 - ө, 86 - ө, 87 - ө, 88 - ө, 89 - ө, 90 - ө, 91 - ө, 92 - ө, 93 - ө, 94 - ө, 95 - ө, 96 - ө, 97 - ө, 98 - ө, 99 - ө, 100 - ө

Хүчин гүйцэтгэх журмын тухай хуулийн 70 - ө, 71 - ө, 72 - ө, 73 - ө, 74 - ө, 75 - ө, 76 - ө, 77 - ө, 78 - ө, 79 - ө, 80 - ө, 81 - ө, 82 - ө, 83 - ө, 84 - ө, 85 - ө, 86 - ө, 87 - ө, 88 - ө, 89 - ө, 90 - ө, 91 - ө, 92 - ө, 93 - ө, 94 - ө, 95 - ө, 96 - ө, 97 - ө, 98 - ө, 99 - ө, 100 - ө

Хүчин гүйцэтгэх журмын тухай хуулийн 70 - ө, 71 - ө, 72 - ө, 73 - ө, 74 - ө, 75 - ө, 76 - ө, 77 - ө, 78 - ө, 79 - ө, 80 - ө, 81 - ө, 82 - ө, 83 - ө, 84 - ө, 85 - ө, 86 - ө, 87 - ө, 88 - ө, 89 - ө, 90 - ө, 91 - ө, 92 - ө, 93 - ө, 94 - ө, 95 - ө, 96 - ө, 97 - ө, 98 - ө, 99 - ө, 100 - ө

Хүчин гүйцэтгэх журмын тухай хуулийн 70 - ө, 71 - ө, 72 - ө, 73 - ө, 74 - ө, 75 - ө, 76 - ө, 77 - ө, 78 - ө, 79 - ө, 80 - ө, 81 - ө, 82 - ө, 83 - ө, 84 - ө, 85 - ө, 86 - ө, 87 - ө, 88 - ө, 89 - ө, 90 - ө, 91 - ө, 92 - ө, 93 - ө, 94 - ө, 95 - ө, 96 - ө, 97 - ө, 98 - ө, 99 - ө, 100 - ө





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 05 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар  
хот

### Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2.Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

### Г.ЗАНДАНШАТАР

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг хавсралтаар батлах тухай

2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр  
Улаанбаатар хот

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг хавсралтаар батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2.Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг хавсралтаар батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2022 оны  
26 дугаар тогтоолын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН  
2023-2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ**

**1.УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР, ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН  
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ, БАЙДАЛ**

**1.1.Улсын нийт гадаад өр<sup>1</sup>**

Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 33.2 тэрбум ам.доллартой тэнцэж байна. Үүнээс Засгийн газрын гадаад өр 8.5 тэрбум ам.доллар /25.6%/, Төв банкны гадаад өр 2.6 тэрбум ам.доллар /7.8%/, бусад салбарын өр 8.2 тэрбум ам.доллар /24.7%/, Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагын өр 1.6 тэрбум ам.доллар /4.8%/, компани хоорондын зээллэг 12.3 тэрбум ам.доллар /37.0%/ыг тус тус эзэлж байна.

Хүснэгт №1: Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл, 2019-2021 он

САЛБАРЫН АНГИЛАЛ	2019	2020	2021
Засгийн газар	7,806.2	8,653.8	8,482.6
Төв банк	1,984.7	2,220.9	2,561.8
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,137.9	1,650.9	1,651.3
Бусад салбар	8,517.4	8,254.2	8,222.0
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	10,366.2	11,405.8	12,272.7
<b>Нийт гадаад өрийн үлдэгдэл</b>	<b>30,702.3</b>	<b>32,361.8</b>	<b>33,190.4</b>

/сая ам.доллар/

Эх сурвалж: Монголбанк

График №1: Улсын нийт гадаад өрийн бүтэц, 2021 он



<sup>1</sup> Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.4-т "улсын нийт гадаад өр"-ийг "Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээс Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн үүрэг" гэж тодорхойлж өгсөн. Тус статистикийг Олон улсын валютын сан /ОУВС/-ийн "Гадаад секторын статистик боловсруулах 6 дугаар гарын авлага"-ын хүрээнд Монголбанк нь Сангийн яамтай хамтран Мэдээлэл тархах ерөнхий системийн шаардлагын дагуу боловсруулж, олон нийтэд мэдээлж байна.

## 1.2.Засгийн газрын өр<sup>2</sup>

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 26,918.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид “ДНБ” гэх/-д эзлэх хувь 50.7 хувьд хүрч, 2019 оны мөн үеэс 4.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №2: Засгийн газрын өр, 2019-2022 он

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	/тэрбум төгрөг/		
	2019	2020	2021
<b>1. Засгийн газрын дотоод өр</b>	<b>1,399.6</b>	<b>1,136.6</b>	<b>657.3</b>
1.1. Үнэт цаас	1,399.6	1,136.6	657.3
<b>2. Засгийн газрын гадаад өр</b>	<b>20,728.1</b>	<b>24,851.4</b>	<b>24,693.3</b>
2.1. Үнэт цаас	7,927.2	8,354.0	8,175.6
2.2. Зээл	12,800.9	16,497.4	16,517.7
<b>3. Бусад өр төлбөр</b>	<b>2072.0</b>	<b>1,910.6</b>	<b>1,550.4</b>
3.1. Засгийн газрын өрийн баталгаа	1,076.3	1,060.4	876.5
3.2. Концесс /Барих-Шилжүүлэх/	995.7	850.2	673.9
3.3. Орон нутгийн зээллэг	-	-	17.2
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР /1+2+3/</b>	<b>24,199.7</b>	<b>27,898.6</b>	<b>26,918.1</b>
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар	75%	70%	70%
Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь	55.1%	62.3%	50.7%

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын үзүүлэлтийг Засгийн газар 2019-2021 онд бүрэн хангаж ажилласан бөгөөд Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалан арилжааны нөхцөлтэй гадаад, дотоод зээллэгийн үлдэгдэл, Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийг бууруулан Засгийн газрын гадаад үнэт цаасны өрийн зохицуулалтын төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан болно.


### 1.2.1.Засгийн газрын дотоод үнэт цаас

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 657.3 тэрбум төгрөгт хүрч, 2020 оны мөн үеэс 479.1 тэрбум төгрөгөөр буураад байна. Засгийн газрын дотоод үнэт цаас буурсан нь 2017 оны 10 дугаар сараас хойш дотоод зах зээлд Засгийн газрын үнэт цаас арилжаалаагүй, хуваарийн дагуу өрийн үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэж байгаатай холбоотой юм.

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 511.6 тэрбум төгрөг /77.8%-ийг төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2018 оноос өмнө арилжаалсан үнэт цаас, 110.7 тэрбум төгрөг /16.8%-ийг “Сайн хувьцаа” хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 35.0 тэрбум төгрөг /5.4%-ийг Хүний хөгжил сангийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас тус тус эзэлж байна.

<sup>2</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д “Засгийн газрын өр гэж өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүн” гэж заасан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т “Засгийн газрын өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 88 хувиас, 2017 оны төсвийн жилд 85 хувиас, 2018 оны төсвийн жилд 80 хувиас, 2019 оны төсвийн жилд 75 хувиас, 2020 оны төсвийн жилд 70 хувиас, 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.” гэж заасан.

График №2: Засгийн газрын дотоод үнэт цаас, 2016-2021 он



Эх сурвалж: Сангийн яам

### 1.2.2. Гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 8,175.6 тэрбум төгрөг байна.

Хүснэгт №3: Гадаад үнэт цаас, 2021.12.31-ний байдлаар


№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Үлдэгдэл
1	Чингис-2022	5.125%	10 жил	389.6
2	Хуралдай	8.750%	7 жил	1,709.1
3	Гэрэгэ	5.625%	5.5 жил	1,518.4
4	Номад	5.125%	5.5 жил	1,709.1
5	Сенчири-2027	3.500%	6 жил	1,424.2
6	Сенчири-2031	4.450%	10 жил	1,424.2
	<b>НИЙТ</b>			<b>8,175.6</b>

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр 600.0 сая ам.долларын 5.125 хувийн хүүтэй “Номад” бондыг арилжаалж, 2021 онд төлөгдөх 10.875 хувийн хүүтэй “Мазаалай” бонд, 2022 онд төлөгдөх 5.125 хувийн хүүтэй “Чингис” бондын тодорхой хэсгийг буцаан худалдаж авав. Мөн “Мазаалай” бондын үлдэгдэл 132.6 сая ам.долларын үндсэн төлбөрийг улсын төсвөөс 2021 оны 04 дүгээр сард бүрэн төлж барагдуулсан юм.

Түүнчлэн 2021 оны 07 дугаар сард “Сенчири” төслийн хүрээнд хугацаа тулаад байсан, 2012 онд гаргасан “Чингис” бонд болон 2017 онд гаргасан “Гэрэгэ” бондын өр төлбөрийн тодорхой хувийг дахин санхүүжилт хийж, өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд түүхэндээ хамгийн бага түвшний хүү болох 3.5 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатай 500 сая ам.доллар болон 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, нийт 1.0 тэрбум ам.долларын өр төлбөрийг шийдвэрлээд байна.


График №3: Дахин санхүүжүүлсэн гадаад үнэт цаас хүүгийн хувиар



Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын үнэт цаасыг олон улсын зах зээл дээр амжилттай арилжаалах, хүүгийн түвшнийг доогуур тогтооход тухайн үеийн дэлхийн зах зээлийн нөхцөл байдлаас гадна үнэт цаас гаргагч орны зээлжих зэрэглэл чухал нөлөөтэй байдаг. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “Мүүдис” агентлаг 2019 онд “В3, хэтийн төлөвийг тогтвортой”, “Фитч” агентлаг “В, хэтийн төлөвийг тогтвортой”, “Эс энд Пи” агентлаг “В+, хэтийн төлөвийг тогтвортой” хэмээн үнэлж байсан бол 2020, 2021 онд зэрэглэл тогтоогч байгууллага тус бүрийн үнэлгээгээр зээлжих зэрэглэл “тогтвортой” хэвээр байв. Монгол Улсын зээлжих зэрэглэл сайжирсан нь төсвийн алдагдлыг бууруулж, ханшийн сулралыг тогтворжуулж, гадаад валютын албан нөөцийг 1.0 тэрбум ам.доллаароос 3.5 тэрбум ам.доллар хүртэл нэмэгдэхэд голлох эерэг нөлөө үзүүлэв. Мөн 2019-2021 онуудад төлөх хуваарьтай гадаад үнэт цааснуудын төлбөрийн тодорхой хэсгийг эдийн засаг, төсөвт дарамт үүсгэхгүйгээр төлж барагдуулсан арга хэмжээ голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

График №4: Монгол Улсын Засгийн газрын зээлжих зэрэглэл, 2016-2021 он



Эх сурвалж: Сангийн яам

### 1.2.3. Гадаад зээл

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орсноос хойш олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, тусламж, техник туслалцааг авч ашиглаж ирсэн. Ингэснээр 2021 оны жилийн эцэст нийт гадаад зээлийн үлдэгдэл 16,517.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь Засгийн газрын нийт өрийн багцын 60.7 хувьтай тэнцэж

хэмжээний дүн юм. Олон улсын банк, санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудаас олгосон хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа 92 төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2021 онд нийт 1,391.4 тэрбум төгрөгийг авч ашигласнаас 285.0 тэрбум төгрөгийг төсвийн дэмжлэгийн зориулалтаар, 1,106.4 тэрбум төгрөгийг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар авч ашиглажээ.

Хүснэгт №4: Гадаад зээлийн ашиглалт, 2019-2021 он

Төрөл	2019	2020	/тэрбум төгрөг/	
			2021	
Хөтөлбөрийн зээл	409.5	1,978.1	285.0	
Төслийн зээл	1,229.1	1,390.3	1,106.4	
<b>НИЙТ</b>	<b>1,638.6</b>	<b>3,368.4</b>	<b>1,391.4</b>	

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын Засгийн газар олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, 2021 онд гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт нийт 945.7 тэрбум төгрөгийг төлөхдөө үндсэн төлбөрт 732.8 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 212.9 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.

Хүснэгт №5: Гадаад зээлийн үйлчилгээ, 2019-2021 он

Төрөл	2019	2020	/тэрбум төгрөг/	
			2021	
Үндсэн төлбөр	438.3	691.0	732.8	
Хүүгийн төлбөр	167.5	197.9	212.9	
<b>НИЙТ</b>	<b>605.8</b>	<b>888.9</b>	<b>945.7</b>	

Эх сурвалж: Сангийн яам

#### 1.2.4.Засгийн газрын өрийн баталгаа

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 876.5 тэрбум төгрөг болж, 2020 оны жилийн эцсээс 183.8 тэрбум төгрөгөөр буурав. Үүнээс Монгол Улсын Хөгжлийн банканд гаргасан баталгааны үлдэгдэл 820.9 тэрбум төгрөг, Монголын иргэний агаарын тээвэр хувьцаат компани /"МИАТ" ХК/-д гаргасан баталгааны үлдэгдэл 29.0 тэрбум төгрөг, "Эрдэнэс Монгол" ХХК-д гаргасан баталгааны үлдэгдэл 26.5 тэрбум төгрөг байна.

Хүснэгт №6: Засгийн газрын өрийн баталгаа, 2021.12.31-ний байдлаар

№	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Валют	2021	
				Үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг
1	"МИАТ" ХК	АНУ <sup>3</sup> -ын Хувийн экспортын санхүүжилтийн корпорац /PEFCO/	Ам.доллар	10.2	29.0
2	Монгол Улсын Хөгжлийн банк	Японы хөрөнгө оруулагчид	Иен	30,000.0	744.0
3	Монгол Улсын Хөгжлийн банк	Хятадын Хөгжлийн банк /China Development Bank/	Ам.доллар	27.0	76.9
4	"Эрдэнэс Монгол" ХХК	Азийн хөгжлийн банк /Asian Development bank/	Ам.доллар	9.3	26.5
<b>НИЙТ</b>					<b>876.5</b>

Эх сурвалж: Сангийн яам

<sup>3</sup> Америкийн Нэгдсэн Улс




Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийн 78.0 хувийг Монгол Улсын Хөгжлийн банкны 30.0 тэрбум иений “Самурай” бондын төлбөр эзэлж байгаа бөгөөд 2023 онд төлөгдөх хуваарьтай бол “МИАТ” ХК-ийн зээл 2023 онд, Монгол Улсын Хөгжлийн банкны Хятадын Хөгжлийн банкнаас авч ашигласан зээл 2022 онд, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн техник, тусалцааны зээл 2031 онд тус тус төлөгдөж дуусах хуваарьтай байна.

### 1.2.5. “Барих-Шилжүүлэх” төрлийн концесс

Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ” гэж заасны дагуу Сангийн яам нь концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас улирал бүр ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг авч нэгтгэн Засгийн газрын өрд бүртгэж байна.

График №5: Барих-Шилжүүлэх төрлийн концесс, 2017-2021



Эх сурвалж: Сангийн яам

Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын өрийн үлдэгдэл 2021 оны эцсийн байдлаар 673.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 176.7 тэрбум төгрөгөөр буурсан. Үүнээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нийт 10 гэрээний өрийн үлдэгдэл 673.5 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нийт 3 гэрээний өрийн үлдэгдэл 0.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

## 2. САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖИТ ЭХ ҮҮСВЭР

### 2.1. Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэр

Засгийн газар 2017 оноос эхлэн Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн болон өрийн удирдлагыг сайжруулах зорилтын хүрээнд өндөр хүүтэй, богино хугацаатай арилжааны зээллэгээс татгалзаж, урт хугацаатай, хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээлийг төсвийн санхүүжилтэд түлхүү авч ашиглаж эхэлсэн.

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээний дийлэнх хувийг гадаад, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсээр ирсэн бол 2022 онд гадаад, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийг үргэлжлүүлэн ашиглахаар төлөвлөсөн.

*Хүснэгт №7: Шинээр татсан эх үүсвэрийн хэмжээ, 2019-2021 он*

<i>/тэрбум төгрөг/</i>			
Эх үүсвэр	2019	2020	2021
Олон талт эх үүсвэр	801.2	2,030.4	942.3
Хоёр талт эх үүсвэр	837.4	1,338.0	449.1
<b>НИЙТ</b>	<b>1,638.6</b>	<b>3,368.4</b>	<b>1,391.4</b>

*Эх сурвалж: Сангийн яам*

## **2.2.Арилжааны нөхцөлтэй гадаад эх үүсвэр**

Засгийн газраас 2012 онд 1.5 тэрбум ам.доллартой тэнцэх “Чингис” бонд, 2015 онд 1.0 тэрбум юань /161.2 сая ам.доллар/-тай тэнцэх “ДимСам” бонд, 2016 онд 500.0 сая ам.доллартой тэнцэх “Мазаалай” бонд, 2017 онд 600.0 сая ам.доллартой тэнцэх “Хуралдай” бонд болон 800.0 сая ам.доллартой тэнцэх “Гэрэгэ” бонд зэрэг нийт 3.6 тэрбум ам.долларын гадаад үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалсан.

ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар арилжааны нөхцөлтэй гадаад зээллэгийг зөвхөн дахин санхүүжилтийн зориулалтаар арилжаалахаар тохирсон бөгөөд шинээр төсөл хөтөлбөр, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар гадаад зээллэг авахыг улирлын шалгуур үзүүлэлтийн дагуу хориглож байв.

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжих хугацаанд 2023 оны 05 дугаар сард “Гэрэгэ” бондын 533.1 сая ам.доллар, 2024 оны 03 дугаар сард “Хуралдай” бондын 600.0 сая ам.доллартой тэнцэх эргэн төлөлтүүд хийгдэх бол 2023 оны 12 дугаар сард Хөгжлийн банкнаас Засгийн газрын баталгаа бүхий “Самурай” төслийн хүрээнд арилжаалсан 30 тэрбум иентэй тэнцэх хөрөнгийг хөрөнгө оруулагчдад эргэн төлөх хуваарьтай байна.

*Хүснэгт №8: Гадаад үнэт цаас, 2021.12.31-ний байдлаар*

<i>/тэрбум төгрөг/</i>					
№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Төлөгдөж дуусах огноо	Үлдэгдэл
1	Чингис-2022	5.125%	10 жил	2022.12	389.6
2	Гэрэгэ	5.625%	5.5 жил	2023.05	1,518.4
3	Хуралдай	8.75%	7 жил	2024.03	1,709.1
4	Номад	5.125%	5.5 жил	2026.04	1,709.1
5	Сенчири-2027	3.5%	6 жил	2027.07	1,424.2
6	Сенчири-2031	4.45%	10 жил	2031.07	1,424.2
<b>Нийт</b>					<b>8,175.6</b>


*Эх сурвалж: Сангийн яам*

Тус төлбөрүүдийг төсвөөс болон гадаад валютын нөөцөөс төлөх нь эдийн засагт томоохон дарамт учруулах эрсдэлтэй тул тодорхой хэсгийг дахин санхүүжүүлж, үлдсэн хэсгийг мөнгөн хуримтлалаас төлж барагдуулахаар төлөвлөж байна.





График №6: Гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн өгөөж, 2019-2021 он



Эх сурвалж: Блүүмберг платформ

Монгол Улсын Засгийн газраас олон улсын зах зээл дээр арилжаалсан үнэт цааснуудын хоёрдогч зах зээлийн хүүгийн түвшин өндөр үед үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үнэ нь нэрлэсэн үнээс буурдаг ба үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаанаас нь өмнө худалдан авах зардал багасдаг байна. Энэ үед буцаан худалдан авах нь өрийг дахин санхүүжүүлэх үр ашигтай арга хэмжээ бөгөөд Өрийн удирдлагын 2019-2021 оны стратегийн баримт бичгийн хэрэгжих хугацаанд Засгийн газар “Мазаалай”, “Чингис” болон “Гэрэгэ” бондуудын тодорхой хэсгийг дахин санхүүжүүлсэн байна.

Түүнчлэн “Чингис”, “Гэрэгэ”, “Хуралдай”, “Номад” болон “Сенчири” төслийн хүрээнд гаргасан үнэт цааснуудын хоёрдогч зах зээлийн өгөөж 2021 оны жилийн эцсийн байдлаар 2.0-оос 5.0 хувьтай байна.

### 2.3. Дотоодын банк, санхүү, хөрөнгийн зах зээлээс татах боломжит эх үүсвэр

Засгийн газар нийт 16.0 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг 2010 оноос 2017 оны хооронд арилжаалсан байна. Үүнээс 10.6 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг арилжааны банк, 1.1 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг Монголбанк, үлдсэн хувийг иргэн, аж ахуйн нэгж, шууд бус хөрөнгө оруулагчид, гадаадын хөрөнгө оруулагчид худалдан авсан.

Монголын хөрөнгийн биржээс 2021 оны жилийн эцсийн байдлаар гаргасан тоо баримтаар нийт 1.4 их наяд төгрөгийн үнэт цаасыг арилжаалсан байна. Үүнээс 74.1 хувийг компанийн үнэт цаас, 21.6 хувийг энгийн хувьцаа, үлдсэн 4.3 хувийг бусад үнэт цаас эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.6 дахин өссөн үзүүлэлт юм.

Арилжаанд оролцогчдын дийлэнх нь дотоодын иргэн, аж ахуйн нэгж ба 2021 оны жилийн эцсийн байдлаар дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар, харин иргэдийн хийсэн арилжаа 5.2 хувиар тус тус өссөн нь дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүд банкны хадгаламжаас татгалзаж үнэт цаасны арилжаанд хөрөнгө оруулж байгааг харуулжээ.

Иймд Засгийн газраас төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг бага зардлаар цаг хугацаанд нь санхүүжүүлэх болон төсвийн санхүүжилтийг хугацаанд нь олгох зорилгоор 2022 оны нэгдсэн төсөвт нийт 2.2 их наяд төгрөгийн Засгийн газрын дотоод үнэт цаас гаргахаар тусгагдсан бөгөөд Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхолтой гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр оролцуулахаар төлөвлөсөн. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг бага зардлаар цаг хугацаанд нь санхүүжүүлэх болон төсвийн санхүүжилтийг хугацаанд нь олгоход Засгийн газрын дотоод үнэт цаас чухал үүрэгтэй. Мөн Засгийн газрын дотоод үнэт цаас нь эрсдэлгүй үнэт цаасанд тооцогддог учир гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татдаг үнэт цаасны төрөл юм.

Монголбанкнаас 2022 оны 03 дугаар сард бодлогын хүүг 2.5 хувиар өсгөж 9 хувь болгосон бөгөөд тус онд арилжаалахаар төлөвлөж байсан Засгийн газрын дотоод үнэт цаасны хүү өсөхөөр байна. Засгийн газрын дотоод үнэт цаасны 90 гаруй хувийг арилжааны банкууд эзэлж байсан бөгөөд Төв банкны үнэт цаасны хүүгээс илүү хүүгээр арилжаалахад богино хугацаат үнэт цаас авах эрэлт өндөр байна.

### **3.ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГААНЫ БАГЦЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Засгийн газраас 2016 оны 06 дугаар сараас хойш шинээр Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй бөгөөд цаашид Засгийн газрын өрийн баталгаа гаргахгүй байх, гаргасан баталгаат зээллэгийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах бодлогыг баримталж байна.

Өрийн удирдлагын тухай хуулийг батлахаас өмнө Монгол Улсын Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын “Евро” бонд, “Самурай” бонд, Кредит Свисс банкнаас авсан зээл, Хятадын Хөгжлийн банкнаас авсан зээл, “МИАТ” ХК-ийн нисэх онгоц худалдан авах зээлд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан бол Өрийн удирдлагын тухай хуулийг баталснаас хойш Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан бонд, Хөгжлийн банкны ОХУ-ын ВТБ банкнаас авсан зээл, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Азийн хөгжлийн банкнаас авсан зээлд тус тус Засгийн газрын өрийн баталгаа гаргасан байна.

#### **Засгийн газрын баталгааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл**

##### **3.1.Хөгжлийн банкны “Самурай” бонд**

Монгол Улсын Хөгжлийн банкны 30.0 тэрбум иентэй тэнцэх хэмжээний 10 жилийн хугацаатай “Самурай” бондыг Япон Улсын зах зээлд Японы Хамтын ажиллагааны банкны баталгаатайгаар /JBIC<sup>4</sup>/ жилийн 1.52 хувийн хүүтэйгээр арилжаалсан. Хөрөнгө оруулагчидтай хийсэн бонд арилжаалах гэрээний дагуу үйл ажиллагааны зардал, шимтгэлийг хассан дүнгээр “Самурай” бондын эх үүсвэр 24.3 тэрбум иен 2014 оны 01 дүгээр сард Хөгжлийн банкны холбогдох дансанд шилжин орж ирсэн. Уг бондын хугацаа 2023 онд дуусах бөгөөд Хөгжлийн банк хүүгийн төлбөрийг тухай бүр бүрэн төлж барагдуулж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар “Самурай” бондын үлдэгдэл төлбөр 30.0 тэрбум иен байна.

<sup>4</sup> Japan Bank for International Cooperation

### **3.2.Хятадын Хөгжлийн банкны зээл**

Хятадын Хөгжлийн банк, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хоёр банкны хамтын ажиллагааг эрчимжүүлэх, БНХАУ-ын оролцоотой хэрэгжиж байгаа төслүүдийг санхүүжүүлэхэд хамтран ажиллах зорилготойгоор Засгийн газрын 2014 оны 116 дугаар тогтоолын дагуу Хятадын Хөгжлийн банкнаас авах 162.0 сая ам.долларын зээлд Монгол Улсын Засгийн газар өрийн баталгаа гаргасан. Зээлийн хугацаа нь 8 жил, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа 3 жил, жилийн тогтмол 6 хувийн хүүтэй бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 27.5 сая ам.долларын үлдэгдэлтэй байна.

### **3.3.“МИАТ” ХК-ийн Боинг нисэх онгоц худалдан авсан зээл болон өрийн бичиг**

Засгийн газрын 2013 оны 319 дүгээр тогтоолын дагуу “МИАТ” ХК-ийн Боинг 767-300 ER агаарын хөлгийг худалдаж авахад зориулсан нийт 121.4 сая ам.долларын зээлд Монгол Улсын Засгийн газар өрийн баталгаа гаргасан бөгөөд дараах гурван дэд зээллэгт хуваагдсан. Үүнд:

- Америкийн Нэгдсэн Улс /АНУ/-ын Экспорт-Импорт банканд 77.4 сая ам.долларын, жилийн тогтмол 2.52 хувийн хүүтэй, 10 жилийн хугацаатай зээл;
- АйЭнЖи капитал банканд 23.9 сая ам.долларын, хувьсах хүүтэй /5.3%+ам.долларын 3 сарын Libor/, 7 жилийн хугацаатай зээл;
- АйЭнЖи банканд 5 жилийн хугацаатай 20.0 сая ам.долларын, хувьсах хүүтэй /9.38+ам.долларын 3 сарын Libor/ өрийн бичиг.

“МИАТ” ХК дээрх баталгаат зээллэгүүдийн төлбөрийг хуваарийн дагуу амжилттай төлж барагдуулж байгаа бөгөөд 2021 онд 8.5 сая ам.долларын зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлж барагдуулснаар Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 10.1 сая ам.доллар байна.

### **3.4.“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкнаас авсан 35.0 сая ам.долларын зээл**

Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх нийт 42.0 сая ам.долларын санхүүжилттэй төслийн зээлийн 85 хувьд буюу Азийн хөгжлийн банкнаас авах 35.0 сая ам.долларын, 15 жилийн хугацаатай, 3 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаатай хувьсах хүүтэй /Spread+ам.долларын 6 сарын Libor/ зээлд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан. Энэхүү зээлийн хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК 2021 оны жилийн эцсийн байдлаар 9.4 сая ам.доллар буюу 19.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Азийн Хөгжлийн банкнаас авсан байна.

## **4.ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛӨЛ БА НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС**


Өрийн тогтвортой байдлын шинжилгээнд аливаа улсын Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ /нэрлэсэн дүнгээр/ 50 хувиас давсан тохиолдолд тухайн улсыг “Сайтар шинжлэх” шаардлагатай орны ангилалд багтаан илүү нарийвчилсан шинжилгээг хийдэг. Монгол Улсын Засгийн газрын өрийн үлдэгдлийн

ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2020 онд 75.5 хувь байгаа бөгөөд 2023 он хүртэл Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй тохиолдолд тус харьцаа хэвээр байх тул “Сайтар шинжлэх” шаардлагатай орны ангилалд орж байна.

Сүүлийн 10 жил болон ирэх 3 жилийн Засгийн газрын өрийн үлдэгдэл, ДНБ-ий харьцаа хэрхэн өсөж, буурахаар байгааг график 7-д харууллаа. Засгийн газрын өрийн хэмжээ 2012-2016 онд ихээхэн хэмжээгээр өссөн байна. Үүнд Засгийн газар өрийн баталгаа гаргаж эхэлсэн, төсөв алдагдалтай батлагдсан, валютын ханш суларч байсан зэрэг үзүүлэлтүүд ихээхэн нөлөө үзүүлжээ. Харин Засгийн газрын өрийн үлдэгдэл, ДНБ-ий харьцаа 2017-2019 онуудад буурсан нь ДНБ-ий өсөлт болон бодит хүүгийн түвшин буурсан зэргээс хамаарсан байна. Цаашид ч бодит ДНБ-ий өсөлтийг дэмжиж, төсвийн үндсэн тэнцлийг бууруулах нь өрийн тогтвортой байдлыг хангах суурь үндэс болохоор байна. Түүнчлэн тус онуудад төгрөгийн бусад валюттай харьцах ханш суларч, төсвийн алдагдлаас шалтгаалан уг харьцаа өсөхөөр байгаа бол бодит ДНБ-ий өсөлт болон бодит хүүгийн түвшнээс шалтгаалан тус харьцааны өсөлт саарахаар байна.

График №7: Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс

ДНБ-д эзлэх хувиар



Эх сурвалж: Сангийн яам

### 5.ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦ ДАХЬ ЗАРДАЛ, ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Зардал, эрсдэлийн шинжилгээний цар хүрээ нь өрийн удирдлагатай холбоотой бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог тодотгон харуулдаг чухал ач холбогдолтой юм. Засгийн газрын өрийн багцыг удирдахдаа зардал, эрсдэлийн шалгуурт үндэслэн багцын зохистой харьцааг тогтоосноор гадаад орчны нөлөөллийн эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх боломжтой юм.

Засгийн газрын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд 2021 оны жилийн эцсийн байдлаар дараах байдалтай байна:



Хүснэгт №9: Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд, 2021.12.31-ний байдлаар

Эрсдэлийн үзүүлэлт		Гадаад зээл	Дотоод зээл	Нийт
Засгийн газрын өр /тэрбум төгрөг/		25,525.2	657.3	26,182.5
Засгийн газрын өр /сая ам.доллар/		8,960.0	225.9	9,185.9
ДНБ-д эзлэх Засгийн газрын өр нэрлэсэн дүнгээр		59.3	1.5	62.6
ДНБ-д эзлэх Засгийн газрын өр өнөөгийн үнэ цэнээр		49.2	1.5	50.7
Өрийн багцын зардал	Хүүгийн төлбөрийн ДНБ-д эзлэх хувь	1.6	0.2	1.8
	Жигнэсэн дундаж хүү /хувь/	2.8	12.6	3
Дахин санхүүжилтийн эрсдэл	АТМ /жил/-эргэн төлөгдөх дундаж хугацаа	8.6	2.3	8.4
	Богино хугацаанд төлөгдөх өр /нийт өрд эзлэх хувь/	3.8	45.3	4.6
Хүүгийн түвшний эрсдэл	Богино хугацаанд төлөгдөх өр /ДНБ-нд эзлэх хувь/	2.9	0.7	3.6
	АТМ /жил/-хүү шинэчлэгдэх дундаж хугацаа	7.6	2.3	7.5
	1 жилд тогтмолжуулах өр /нийт өрд эзлэх хувь/	16.2	45.3	16.7
	Тогтмол хүүтэй зээл ба үнэт цаас /нийт өрд эзлэх хувь/	87	100	87.2
Ханшийн эрсдэл	Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр /нийт өрд эзлэх хувь/			97.5
	Валютын нөөцөд эзлэх богино хугацаат гадаад өр			9.5

### 5.1.Өрийн багцын зардал /хүүгийн төлбөр/

Өрийн багцын зардал 2021 оны жилийн эцсийн байдлаар ДНБ-ий 1.8 хувьтай тэнцэж байна. Үүнээс Засгийн газрын гадаад өрийн зардал ДНБ-ий 1.6 хувь, дотоод өрийн зардал ДНБ-ий 0.2 хувь байна. Өрийн багцад эзлэх дотоод өрийн зардал буурахад Засгийн газраас 2017 оны 10 дугаар сараас өндөр хүүтэй дотоод үнэт цаасны арилжааг зогсоож, зарим үнэт цаасыг хугацаанаас өмнө буцаан худалдан авсан нь чухал нөлөө үзүүлсэн.

Түүнчлэн 2021 оны жилийн эцсийн байдлаар жигнэсэн дундаж хүү<sup>5</sup> 3.0 хувьтай байна. Үүнд гадаад өрийн жигнэсэн дундаж хүү 2.8 хувь, дотоод өрийн жигнэсэн дундаж хүү 12.6 хувь байна.

### 5.2.Өрийн багцын эрсдэл

#### 5.2.1.Дахин санхүүжилтийн эрсдэл

Монгол Улсын Засгийн газрын 2012 онд арилжаалсан 1,000.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээтэй “Чингис” бонд, 2017 онд арилжаалсан 500.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээтэй “Мазаалай” бондын хугацаа 2021 болон 2022 онуудад дуусаж, дахин санхүүжилтийн эрсдэлтэй тулгарч байсныг 2020 онд 600.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээтэй “Номад” бонд, 2021 онд 1,000.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээтэй

<sup>5</sup> Өрийн жигнэсэн дундаж хүү нь тайлант үеийн эцсийн өрийн үлдэгдэл болон тухайн зээлийн хүүгийн үржвэрийн нийлбэрийн нийт өрийн үлдэгдэлд харьцуулсан харьцаа юм.

“Сенчири” бондыг олон улсын зах зээлд арилжаалж, үлдсэн хэсгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр санхүүжүүлж, төсөв, гадаад валютын албан нөөцөд дарамт учруулахгүйгээр төлж барагдуулсан.

Мөн Засгийн газар 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс дотоод үнэт цаасны арилжааг зогсоож, үнэт цаасны төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулж байна. Ингэснээр Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 657.3 тэрбум төгрөг болж буурсан.

Үүний үр дүнд 2018 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын өрийн багцын хувьд дахин санхүүжилтийн эрсдэл харьцангуй бага түвшинд буюу нийт багцын хүрээнд эргэн төлөлтийн дундаж хугацаа /АТМ/<sup>6</sup> 8.4 жилтэй тэнцэж байна.

Түүнчлэн 2023, 2024 онд “Гэрэгэ”, “Хуралдай” бондуудын төлбөр төлөгдөх учир дахин санхүүжүүлэх, мөнгөн хуримтлалын үлдэгдлээс төлөх зэрэг өрийн зохицуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### **5.2.2. Хүүгийн түвшний эрсдэл**

Засгийн газрын өрийн багц дахь хүү тогтмолжуулах дундаж хугацаа 7.5 жил байна. Үүнээс гадаад өрийн хүү тогтмолжуулах дундаж хугацаа /АТМ/ 7.6 жил байгаа бол дотоод өрийн хүү тогтмолжуулах дундаж хугацаа /АТМ/ харьцангуй бага буюу 2.3 жил байна.

Хүү тогтмолжуулах дундаж хугацаа нь тухайн өрийн хэрэгслийн хүү дунджаар хэдэн жилийн дотор бүрэн шинэчлэгдэхийг тооцоолдог үзүүлэлт ба үүнд хувьсах хүүтэй өрийн хүү жилийн дотор бүрэн шинэчлэгддэг бол өр төлөгдөж дуусахаар түүнийг дахин санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд шинэ хүү тогтдог.


АНУ-д инфляц 2022 оны 03 дугаар сард сүүлийн 40 жилийн хамгийн дээд түвшиндээ хүрсний улмаас тус улсын Төв банкнаас урт хугацаан дахь бодлогын хүүгийн түвшинг 2 хувь болгох талаар мэдэгдэл хийгээд байна. Ийнхүү АНУ-ын бодлогын хүү өсөх нь Засгийн газрын өрийн багцад эзлэх хувьсах хүүгийн зардлыг өсгөх эрсдэлийг нэмэгдүүлж, энэ нь тус зээлүүдийг тогтмол хүүтэй болгоход том нөлөөтэй болох юм. Иймд хувьсах хүүтэй зээлийн үлдэгдэл буурснаар тус үзүүлэлт өсөх магадлалтай болж байна.

### **5.2.3. Валютын ханшийн эрсдэл**

Өрийн багцыг валютын бүтцээр харвал Засгийн газрын өрийн 63 хувь нь ам.доллар, 17 хувь нь зээлжих тусгай эрх, 15 хувь нь иен, 3 хувь нь евро, 2 хувь нь бусад валютаас бүрдсэн байна.

<sup>6</sup> Эргэн төлөгдөх дундаж хугацаа нь тухайн өрийн үлдэгдэл дунджаар хэдэн жилийн дотор төлөгдөж дуусахыг тооцоолдог үзүүлэлт ба үүнийг зээллэгийн үлдсэн хугацааг тухайн зээллэгийн үлдэгдлээр үржин нийт өрийн үлдэгдэлд харьцуулж олно.

График №8: Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр, валютын бүтцээр,  
2021.12.31



Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын өрийн багцын гадаад валютаар илэрхийлэгдсэн өрийн хэмжээ 2021 оны байдлаар 97.5 хувийг эзэлж байна. Энэ нь Засгийн газрын дотоод үнэт цаас 2017 оноос хойш арилжаалаагүй, мөн гадаад зээл ашиглалт болон валютын ханшийн өсөлтөөс шалтгаалж байна.

### 5.3.Зардал эрсдэлийн шинжилгээ

Дунд хугацааны өрийн стратегийн зардал, эрсдэлийн шинжилгээнд Дэлхийн банк, ОУВС-ийн хамтран боловсруулсан өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн шинжилгээний загварыг ашигласан бөгөөд уг загварт Засгийн газрын өрийн хэрэгслүүдийг дараах байдлаар багцаллаа:

Хүснэгт №10 Засгийн газрын өрийн хэрэгслүүдийн багц

Төрөл	Ангилал / нэр	Fix <sup>7</sup> / Var <sup>8</sup>	Хугацаа /жил/	Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа /жил/	Валютын төрөл	Валют
USD 2	ДБ/ХААХОУС <sup>9</sup>	тогтмол	25	5	FX	USD
USD 3	IBRD/АХБ	тогтмол	25	5	FX	USD
USD 4	IBRD/АХБ	хувьсах	25	5	FX	USD
USD 5	Хоёр талт	тогтмол	20	5	FX	USD
USD 6	Олон улсын үнэт цаас	тогтмол	5	4	FX	USD
USD 7	Арилжааны зээл	тогтмол	5	3	FX	USD
USD 8	Арилжааны зээл	хувьсах	6	2	FX	USD
MNT_11	Богино хугацаат үнэт цаас	тогтмол	1	0	DX	MNT
MNT 12	Үнэт цаас /2 жил/	тогтмол	2	1	DX	MNT
MNT 13	Үнэт цаас /3 жил/	тогтмол	3	2	DX	MNT
MNT 14	Үнэт цаас /5 жил/	тогтмол	5	4	DX	MNT
MNT 15	Үнэт цаас /7 жил/	тогтмол	7	6	DX	MNT
MNT 16	Үнэт цаас /10 жил/	тогтмол	10	9	DX	MNT
MNT 17	Үнэт цаас /15 жил/	тогтмол	15	14	DX	MNT

<sup>7</sup> Fixed буюу тогтмол

<sup>8</sup> Variable буюу хувьсах

<sup>9</sup> Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан /IFAD/

### Өрийн удирдлагын боломжит хувилбарууд

Загварт олгож байгаа боломжийн дагуу дараах 4 боломжит стратегийг сонгон авч, үр дүнд шинжилгээ хийлээ. Үүнд:

**Стратеги 1 (S1):** Санхүүжилтийн хэрэгцээг санхүүжүүлэхээр жилд төсөл, хөтөлбөрийн зээл шинээр авч ашиглаж, дотоод бонд арилжаалах;



**Стратеги 2 (S2):** Санхүүжилтийн хэрэгцээг төслийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, төсвийн алдагдал санхүүжүүлэхээр арилжааны нөхцөлтэй зээл шинээр авч ашиглаж, дотоод бондын арилжаагаар санхүүжүүлэх;

**Стратеги 3 (S3):** Санхүүжилтийн хэрэгцээг санхүүжүүлэхээр хөтөлбөрийн зээл авч ашиглахгүй, төслийн зээл шинээр авч ашиглах болон дотоод бонд арилжаалан санхүүжүүлэх;

**Стратеги 4 (S4):** Төсөл хөтөлбөрүүдийг хөгжлийн үнэт цаас арилжаалан санхүүжүүлэх, санхүүжилтийн хэрэгцээг дотоод бонд арилжаалан санхүүжүүлэх.

#### Хүснэгт №11: Засгийн газрын өрийн дунд хугацааны зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд

Эрсдэлийн индикатор		2021	2025			
		Суурь	S1	S2	S3	S4
ДНБ-д эзлэх Засгийн газрын өр нэрлэсэн дүнгээр		62.6	61.7	69.0	65.6	62.0
ДНБ-д эзлэх Засгийн газрын өр өнөөгийн үнэ цэнээр		50.7	54.1	60.6	58.4	55.3
Хүүгийн төлбөрийн ДНБ-нд эзлэх хувь		1.8	2.4	2.5	2.8	2.9
Жигнэсэн дундаж хүү /хувь/		3.0	4.7	4.5	5.1	5.7
Дахин санхүүжилтийн эрсдэл	Богино хугацаанд төлөгдөх өр /Нийт өрд эзлэх хувь/	4.9	13.5	11.8	14.1	14.2
	Богино хугацаанд төлөгдөх өр /ДНБ-д эзлэх хувь/	4.0	8.3	8.2	9.2	8.8
	Гадаад өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	8.6	7.8	7.6	7.4	7.6
	Дотоод өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	3.2	2.8	2.8	2.8	3.1
	Нийт өрийн багцын эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	8.4	7.0	7.0	6.5	6.4
Хүүгийн түвшний эрсдэл	Хүү шинэчлэгдэх дундаж хугацаа /жил/	7.5	6.6	6.7	6.1	6.0
	1 жилд тогтмолжуулах өр /нийт өрд эзлэх хувь/	18.2	19.5	17.3	19.9	19.9
Ханшийн эрсдэл	Тогтмол хүүтэй зээл ба бонд /нийт өрд эзлэх хувь/	85.6	93.3	93.9	93.5	93.6
	Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр /нийт өрд эзлэх хувь/	97.5	80.0	85.0	76.6	67.8
	Валютын нөөцөд эзлэх богино хугацаат гадаад өр /хувь/	9.5	17.1	19.0	17.1	17.1





**Дүгнэлт:**

Шинжилгээний үр дүнгээс үзэхэд дотоод бондоор санхүүжилтийн хэрэгцээг бүхэлд нь санхүүжүүлэх /S3, S4/ нь ханшийн эрсдэлийг багасгаж байгаа ч өрийн үйлчилгээний зардлыг ихэсгэснээр өрийн үйлчилгээний эрсдэл өндөр гарч байна. Цаашлаад арилжааны зээлийг ашигласнаар /S2/ гадаад валютаар илэрхийлэгдсэн өрийн хэмжээг ихэсгэж, ханшийн эрсдэлийг өсгөж байна. Харин төсвийн алдагдлыг санхүүжүүлэх гадаад эх үүсвэрийг хязгаарлаж, дотоод эх үүсвэр ашиглах нь гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулж, гадаад өрийн дарамтыг бууруулах ач холбогдолтой болохыг шинжилгээний үр дүн харуулж байна.

**6.ДУНД ХУГАЦААНД ДЭВШҮҮЛЖ БАЙГАА ЗОРИЛТ,  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ**

**Зорилт 1:Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.**

**Үндэслэл:**Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3.2-т “Засгийн газрын авах зээл нь бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан, зохистой харьцаанд байна” гэж заасан. Түүнчлэн 2021 он хүртэл байгуулагдаад байгаа гадаад зээлийн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд авч ашиглаагүй зээлийн хэмжээ 13.5 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа ба зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу энэхүү ашиглаагүй зээлийн хөрөнгийг 3-5 жилийн хугацаанд авч ашиглах үүрэг хүлээсэн. Энэ хэмжээгээр төсвийн хөрөнгийн зардал тэлэх, цаашлаад төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх суурь шалтгаан болох төлөвтэй байна. Монгол Улсын Засгийн газрын зүгээс энэхүү ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд 2021 онд 16 орчим тэрбум төгрөгийн шимтгэл төлсөн байдаг. Цаашид Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, ашиглагдаагүй зээлийн хэмжээг хязгаарлах, гадаад зээлийн гэрээ хэлэлцээр байгуулахаас өмнөх төслийн бэлтгэл ажлыг монголын талаас шуурхай хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Иймд гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн бэлэн байдал хангагдсан, бодит секторт чиглэсэн төслүүдэд хөрөнгө оруулалт хийснээр Засгийн газрын гадаад зээлийн бодлогын хэрэгжилт сайжирч, төсвийн зардал дахь ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлж байгаа шимтгэлийн хэмжээ буурах нөхцөл бүрдэнэ.

**Хэрэгжүүлэх арга зам:**

- Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзах;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д<sup>10</sup> зааснаас бусад тохиолдолд зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээл авч ашиглах;
- Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг хийхгүй байх.

<sup>10</sup> Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д “нийгмийн үр өгөөжтэй, улсын төсөвт эргэн төлөгдөх чадваргүй төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр санхүүжүүлэх эсэхийг тухайн жилийн төсвийн хуулиар, шаардлагатай тохиолдолд тухай бүр шийдвэрлэх” гэж заасан.

**Зорилт 2:Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.**

**Үндэслэл:**Дэлхийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын хөрөнгийн зах зээлийн гэнэтийн өөрчлөлт, төлөв байдлаас хамааран Засгийн газрын гадаад өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагууд энэхүү стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд үүснэ. Тухайлбал 2023, 2024 онд Засгийн газрын гадаад үнэт цаасны төлөлтийн хувьд өндөр ачаалалтай жилүүд болж байна.

**Хэрэгжүүлэх арга зам:**

- Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийж, Засгийн газрын гадаад үнэт цаасыг хугацаанаас нь өмнө худалдан авах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх, өрийн зохицуулалтын арга хэмжээ, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалахгүй байх;
- Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханган хамтарч ажиллах.

**Зорилт 3:Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.**

**Үндэслэл:**Дэлхийн хамгийн том эдийн засаг болох АНУ-д инфляц 2022 оны 03 дугаар сарын байдлаар сүүлийн 40 жилийн хугацаанд хамгийн дээд түвшиндээ хүрсний улмаас тус улсын Төв банкнаас бодлогын хүүгийн түвшнийг 2 хувьд хүргэх тухай урт хугацааны зорилтоо олон нийтэд мэдэгдсэн. Улмаар АНУ-ын бодлогын хүү өсөх нь ам.долларын ханш бусад улсын валютын эсрэг чангарах, дэлхийн санхүүгийн зах зээл дэх суурь хүүг нэмэгдүүлэх зэрэг нөлөө үзүүлснээр Засгийн газрын өрийн багц дахь валютын болон хүүгийн түвшний эрсдэлийг нэмэгдүүлэх, гадаад өрийн дахин санхүүжилтийн зардлыг өсгөх зэрэг сөрөг үр дагавар бий болохоор байгаа тул Засгийн газраас цаашид дээрх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Хэрэгжүүлэх арга зам:**

- Засгийн газрын хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанкт хамтран ажиллаж, гадаад өрийн үйлчилгээний хуваарийг валютын нөөцтэй уялдуулах, шаардлагатай тохиолдолд валют болон хүүгийн своп хэлэлцээрийг зээлдүүлэгч талтай хийх;
- Дэлхий нийтэд тулгараад байгаа нь инфляцын өсөлтөөс шалтгаалан гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн өсөлтөөс хамааран урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн хөвөгч хүү өсөх тохиолдолд тогтмол хүүтэй зээл авах нөхцөлийг зээлдүүлэгч талд тавьж ажиллах;
- Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн төсөл, арга хэмжээг дэмжиж, тэдгээрийн санхүүжилтийг Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн өрийн хэрэгсэлтэй уялдуулж, Засгийн газрын өрийн зохицуулалтын арга хэмжээнд нэвтрүүлэх

боломжийг судалж, бэлтгэл ажлыг хангуулахад холбогдох яамтай хамтран ажиллах, түүнчлэн эдгээр арга хэмжээний ач холбогдлыг олон нийтэд таниулах;

- Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний нэгдсэн системийг сайжруулж, мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Орон нутгийн засаг захиргааны өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, Засгийн газрын өрийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх талаар хамтран ажиллах.

**Зорилт 4:Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.**

**Үндэслэл:**Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа нь хөрөнгийн зах зээл, үнэт цаасны зах зээлийн хөгжилд чухал нөлөөтэйн зэрэгцээ төсвийн алдагдлыг санхүүжүүлэх найдвартай эх үүсвэр болдог тул дотоод өрийн зах зээлийг хөгжүүлэх зорилт нь Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу стратегийн баримт бичгийн зорилго, хамрах хүрээний салшгүй хэсэг болж хуульчлагдсан. Иймд 2017 оны 10 дугаар сараас эхлэн зогссон Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн арилжааг дахин нээж, тогтмолжуулах шаардлагатай байна. Засгийн газрын дотоод үнэт цаасны өгөөжийн муруйг бий болгосноор хөрөнгийн зах зээлд эрсдэлгүй үнэт цаасны жишиг хүү тогтох ач холбогдолтой бөгөөд Засгийн газрын үнэт цаасны арилжааг урьдчилан зарласан хэмжээ, нөхцөл бүхий хуваарийн дагуу тогтсон хугацаанд зохион байгуулж хэвшсэнээр үнэт цаасны эрэлтийг дэмжиж, өгөөжийн муруйг бий болгох нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Иймээс зарим тохиолдолд Төрийн сан дахь мөнгөн хөрөнгийн дутагдал үүсээгүй байхад Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.3-т заасан зориулалтаар буюу дотоод өрийн зах зээлийг хөгжүүлэх зориулалт бүхий үнэт цаасны арилжааг хэвийн явуулах шаардлагатай болно.

**Хэрэгжүүлэх арга зам:**

- Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан систем нэвтрүүлэх;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч арилжаанд оролцсоноор бий болох үр ашиг, эрсдэлийн талаар иргэн, аж ахуйн нэгжийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн хөрөнгө оруулагчдын бааз суурийг нэмэгдүүлэх;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах, зорилтот зах зээлд чиглэсэн Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зохион байгуулах дэд бүтэц болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээл дэх жишиг хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор жил бүр шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны 10-20 хүртэлх хувийг урьдчилан зарласан хугацаа, нөхцөл бүхий хуваарийн дагуу арилжаа зохион байгуулагдахаас 3 сарын өмнө олон нийтэд нээлттэй зарлаж, хуваарийн дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулах замаар арилжааг тогтмолжуулах.

**Зорилт 5:Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол**

**Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана.**

**Үндэслэл:**Монгол Улсын Их Хурлаас “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолыг баталсан. Энэ бодлогын баримт бичиг нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байгаа хүчин зүйлсийг арилгаж, урт хугацааны эдийн засгийн өсөлтийг хангах зорилтот төсөл, хөтөлбөрүүд, хуулийн төслүүд, үйл ажиллагааны хөтөлбөрүүдээс бүрдсэн. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа нийтлэг асуудлууд нь төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангалтгүй /техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, зураг, төсөл боловсруулагдаагүй, шинэчлэх шаардлагатай гэх мэт/ байхын зэрэгцээ, төслийг санхүүжүүлэх улсын төсвийн боломж, бололцоо хомс байдаг. Иймд төслийн бэлтгэл ажил хангагдсан төсөл, хөтөлбөрийн хувьд улсын төсөвт дарамт учруулахгүйгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжит хувилбар бол хөрөнгө оруулалтын эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах явдал юм.

**Хэрэгжүүлэх арга зам:**

- Эдийн засаг болон нийгмийн үр өгөөж өндөртэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан, “Шинэ сэргэлтийн бодлого”-д нийцсэн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гаргах Засгийн газрын өрийн баталгаанаас төсөвт үүсэж болзошгүй эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүртгэл хөтлөх, тайлагнах механизмыг бүрдүүлэх;
- Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслүүдийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах;
- Төсвөөс шууд төлөгдөх нөхцөлтэй Барих-Шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулахгүй, өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байх;
- Олон улсын санхүүгийн байгууллагуудаас санал болгож байгаа болзошгүй эрсдэлээс сэргийлэх зээлийн шугамыг ашиглах механизмыг нэвтрүүлэх.

**Зорилт 6:Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна.**

**Үндэслэл:**Өрийн ил тод байдлыг хангуулах, олон нийтэд үнэн, бодитой мэдээлэл хүргэх нь иргэн, аж ахуйн нэгжид Засгийн газрын үйл ажиллагааг таниулах, төсөвт үүсэж болзошгүй өр төлбөрийн талаар зөв ойлголтыг өгөх, түүнчлэн хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, олон улсын санаачилгын хүрээнд дэлхийн нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу өрийн статистик мэдээлэлд Монгол Улсын Засгийн газрын өрийн бүртгэлийг нэгтгүүлэх зэрэг ач холбогдолтой байдаг. Энэ талаар олон улсын байгууллагууд, тэр дундаа Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас Монгол Улсад хуваарилах дунд хугацааны зээлийн хэмжээ, нөхцөлийг тогтооход тавигдсан өрийн ил тод байдлыг хангуулах бодлогын нөхцөлүүдтэй энэхүү зорилт нийцэж байна.

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

- Улирал бүр Засгийн газрын өрийн товхимлыг олон нийтэд ил тод мэдээлэх;
- Улсын секторын өрийн мэдээллийг олон улсын байгууллагаас тогтоосон нэгдсэн стандартын дагуу бэлтгэж, мэдээлэх.



### 7.ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТ

Засгийн газрын өрийн багцын зорилтот бүтцийг Олон улсын валютын сан, Дэлхийн банкны боловсруулсан MTDS<sup>11</sup> загварчлалыг ашиглан боловсруулсан болно.

Дэвшүүлсэн зорилтын хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дунд хугацаанд хүрэх Засгийн газрын өрийн багцын дараах төсөөлөл, зорилтот бүтцийг хангаж ажиллана.Үүнд:

*Хүснэгт №12: Дунд хугацааны төсөөлөл, зорилтот бүтэц*

Засгийн газрын өрийн багцын үзүүлэлтүүд	2022	Түвшин	2023	2024	2025
<b>1. Өрийн зардал</b>					
Жигнэсэн дундаж хүү /хувь/	3.0	Дээд	3.8	4.3	4.8
<b>2. Дахин Санхүүжилтийн эрсдэл</b>					
Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	8.4	Доод	7.8	7.3	6.8
<b>3. Хүүгийн эрсдэл</b>					
Засгийн газрын өрийн ATR /жил/	7.5	Доод	7.0	6.5	6.3
<b>4. Ханшийн эрсдэл</b>					
Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр* /нийт өрд эзлэх хувь/	78.8	Дээд	80.0	80.0	80.0

*\*Гадаад валютаар илэрхийлэгдсэн өрийн эзлэх хувийг тооцоходоо Засгийн газрын өрийн баталгааны үлдээдлийг оруулж тооцоогүй болно.*

---oOo---

<sup>11</sup> Medium-term debt management strategy

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд Зөвшөөрлийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Валютын зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Далай ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн

нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Патентийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасгай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

### Урсгалын үзүүлэлтүүдийн талаар

Хувиар тусгай үзүүлэлтүүдийн талаар

Тусгай үзүүлэлтүүдийн талаар

Тусгай үзүүлэлтүүдийн талаар

Тусгай үзүүлэлтүүдийн талаар

Тусгай үзүүлэлтүүдийн талаар

Тусгай үзүүлэлтүүдийн талаар









## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг улсын хэмжээнд 2022 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 26-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.

2. Ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтийн саналыг судлах сэдвийн хүрээг 1 дүгээр хавсралтаар, ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлын арга, хэлбэрийг тодорхойлж, зохион байгуулах, дүнг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

4. Энэ тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**С.ОДОНТУЯА**

Монгол Улсын Их Хурлын 2022 оны  
34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

**Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт  
оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод  
байдлыг хангах зорилгоор олон нийтийн саналыг  
судлах сэдвийн хүрээ**

**1.Хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн хамгаалалтыг  
бэхжүүлэх талаар:**

1/хүний эрхэм чанар халдашгүй байна. Төр нь хүний эрхэм чанарыг хүндэтгэн хамгаалах үүргийг иргэнийхээ өмнө хүлээнэ. /Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл/;

2/хүний амьд явах эрхийн баталгааг хангаж, цаазын ялыг халах /Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх заалт/;

3/иргэний эвлэлдэн нэгдэх эрхэд Үндсэн хуулиар тавьсан хязгаарлалтыг арилгах /Үндсэн хуулийн Арван ес<sup>1</sup> дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/;

4/иргэн үндсэн эрхээ хуульд заасан хязгаарын хүрээнд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргаж, хамгаалуулах боломжтой болох /Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг/;

5/Үндсэн хуулийн цэц нь аливаа улс төрийн нөлөөллөөс хараат бус байх, Үндсэн хуулийн шүүхийн хувьд ажиллах зарчмыг гүнзгийрүүлэн бэхжүүлэх /Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг/.

**2.Ард түмнийг төлөөлөх парламентын чадавх, хариуцлагыг  
нэмэгдүүлэх талаар:**

1/улс төрийн намын төлөвшил, хариуцлагыг дээшлүүлэх, сонгогчдын санал гээгддэг байдлыг арилгах, сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх, зөвшилцлийн ардчиллыг бэхжүүлэх /Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэг/;

2/ард түмнийг төлөөлөх парламентын чадавхыг сайжруулах, хууль батлах болон хуулийн биелэлтэд тавих хяналтын чанарыг дээшлүүлэх зорилгоор сонгогчдыг төлөөлөх мандатын тоог нэмэгдүүлэх, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон парламентын засаглалыг төгөлдөржүүлэх /Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг/;

3/хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хяналт тэнцэл, уялдаа холбоог зохистой болгох /Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг/.

**3.Хот, хөдөөгийн хөгжлийг дэмжих, нутгийн удирдлагын тогтолцоог сайжруулах талаар:**

1/нийслэлийн эрх зүйн байдлыг оновчтой болгох, төвлөрлийг сааруулж хот, хөдөөгийн ялгааг багасгах, хөгжлийн нэг төвтэй улсаас олон төвтэй улс болгох зорилгоор бусад хотын хөгжлийг дэмжих /Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавин долдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг/;

2/орон нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох /Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг/.

**4.Монгол Улсын Төрийн сүлдийг шинэчлэх талаар:**

1/Төрийн сүлдийг төрт ёс, түүхэн уламжлалд суурилж шинэчлэх /Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэг/.

---o0o---

Монгол Улсын Их Хурлын 2022 оны  
34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

**Ажлын хэсэг байгуулах тухай**

1.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Ж.Мөнхбат -Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга

**Гишүүд:**

Д.Тогтохсүрэн -Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга

Д.Ганбат -Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга



Б.Баттөмөр	-Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга
Х.Болорчулуун	-Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга
Г.Дамдинням	-Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга
Б.Бат-Эрдэнэ	-Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга
Н.Учрал	-Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга
М.Оюунчимэг	-Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга
Ч.Хүрэлбаатар	-Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга
Б.Чойжилсүрэн	-Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга
С.Бямбацогт	-Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга
Ж.Ганбаатар	-Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга
Т.Доржханд	-Улсын Их Хурлын гишүүн
Ц.Туваан	-Улсын Их Хурлын гишүүн
<b>Нарийн бичгийн дарга:</b>	
Ж.Бямбадулам	-Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга

---000---



Үүсгэнэ, хичвэр, гэр бүл үүсгэнэ гэр бүл 01001 үср 9  
01001 үүсгэнэ үүсгэнэ гэр бүл үүсгэнэ үүсгэнэ

Үүсгэнэ, хичвэр, гэр бүл үүсгэнэ үүсгэнэ, үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ, үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ

6. Үүсгэнэ, гэр бүл үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ :

6/ Үүсгэнэ, гэр бүл үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ

7/ Үүсгэнэ, гэр бүл үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ

8/ Үүсгэнэ, гэр бүл үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ

9/ Үүсгэнэ, гэр бүл үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ

10/ Үүсгэнэ, гэр бүл үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ,  
үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ

11. Үүсгэнэ, гэр бүл үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ үүсгэнэ :





6 | Мийэр мэдэгдэ хүр нэг мр мэдигүүлж , нэгдэмтэйгэ хүр мэрнэйгээр хэлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж .

7 | Мийэр мэдэгдэ хүр нэг мр мэдигүүлж , нэгдэмтэйгэ хүр мэрнэйгээр хэлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж .

8 | Мийэр мэдэгдэ хүр нэг мр мэдигүүлж , нэгдэмтэйгэ хүр мэрнэйгээр хэлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж .

9 | Мийэр мэдэгдэ хүр нэг мр мэдигүүлж , нэгдэмтэйгэ хүр мэрнэйгээр хэлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж .

10 | Мийэр мэдэгдэ хүр нэг мр мэдигүүлж , нэгдэмтэйгэ хүр мэрнэйгээр хэлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж .

11 | Мийэр мэдэгдэ хүр нэг мр мэдигүүлж , нэгдэмтэйгэ хүр мэрнэйгээр хэлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж .

12 | Мийэр мэдэгдэ хүр нэг мр мэдигүүлж , нэгдэмтэйгэ хүр мэрнэйгээр хэлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж , мэрнэйгээр хэлж н мэдигүүлж .



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар  
хот

### **Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг шинэчлэн тогтоож, зарим орчныг олон нийтэд нээлттэй болгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг Төрийн ордны баруун, зүүн талын хашаа болон Төрийн ордны хойд талын цэцэрлэгт хүрээлэнгийн урд талын хашаа, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборын барилгын бүтээцийн урд хязгаараар тооцож тогтоосугай.

2.Төрийн ордны хойд талын цэцэрлэгт хүрээлэнг иргэд, олон нийтэд нээлттэй болгосонтой холбоотойгоор цэцэрлэгт хүрээлэнгийн аюулгүй байдал, хамгаалалтын асуудлыг зохион байгуулах, хэв журмыг сахиулах, иргэдийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, цэвэрлэгээ, арчилгаа, тохижилтыг хариуцах асуудлыг холбогдох журмаар зохицуулахыг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор Төрийн ордны хойд талын цэцэрлэгт хүрээлэнгийн хашааг шинэчлэн засварлах, камержуулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэхийг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааг иргэдэд тайлбарлан таниулах, ил тод, нээлттэй болгох зорилгын хүрээнд Улсын Их Хурлын гишүүнтэй уулзах, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцах иргэдийг Төрийн ордонд нэвтрэхэд энгийн хувцаслалттай байхыг зөвшөөрсүгэй.

5.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, зааг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2001 оны 16 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**ЮУСАНХ САНСАРЫН ХУРИЙН ТӨЛӨӨ**

Хурлын дарга Г.Занданшатар /2022.09.09/

Хурлын дарга Г.Занданшатар /2022.09.09/

Хурлын дарга Г.Занданшатар /2022.09.09/

Хурлын дарга Г.Занданшатар /2022.09.09/

Хурлын дарга Г.Занданшатар /2022.09.09/



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилох тухай

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жаргалсайханы Хунанг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠣᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠣᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠣᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠣᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠣᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠣᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠣᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ  
ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ

ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ ᠲᠣᠭᠲᠤᠭᠣᠯ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах саналыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон нийт гишүүний олонх дэмжээгүй тул төслийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Үндэсний их баяр наадмын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл буцаах тухай

2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр  
Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 7.75

**Индекс: 200003**



